



**ШИВЭЭ ОВОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
2024 ОНЫ ТАЙЛАН**



**2024 он**

## АГУУЛГА

1. Ерөнхий мэдээлэл
  - Компанийн удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн талаар
  - 2024 оны онцлох үйл явдлуудаас
2. Үйл ажиллагааны тайлан
  - Уулын үйлдвэрлэл, технологи ажлын талаар
  - Техникийн шинэчлэл болон хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын талаар авч хэрэгжүүлсэн ажлын талаар
3. Санхүү, эдийн засгийн талаар
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс
5. Байгаль орчин
6. Удирдлагын бусад чиг үүргийн талаар
  - Байгууллагын соёлын талаар
  - Хууль тогтоомж бодлого шийдвэрийн талаар
  - Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлууд
  - Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар

## НЭГ: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


“Шивээ Овоо”-гийн уурхай нь жилдээ дунжаар 8.6 сая.м3 хөрс хуулж, 2.0 сая.тн нүүрс олборлон, борлуулах хүчин чадалтай ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн ЭБМЗ-ийн хурлаар, улсын төвийн эрчим хүч, дулааны хэрэглээний өсөлтийг үндэслэн 4.5 сая тн нүүрс олборлох ТЭЗҮ-г хэлэлцүүлж, 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан билээ.

Улаанбаатар хотоос зүүн урагшаа 260 км-т Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт Улаанбаатар-Бээжингийн олон улсын төмөр замын дэргэд далайн төвшнөөс 1180-1230 метрт оршино.



“Шивээ Овоо” ХК нь Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 58.7%, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 54.8%-ийг хангадаг Монгол Улсын эрчим хүч, дулааны хамгийн том үйлдвэр “ДЦС-4” ТӨХК-ийн нүүрсний хэрэглээний **50%**-ийг хангаж буй **Стратегийн ач холбогдол** бүхий хүрэн нүүрсний уурхай.

Компанийн нийт хувьцааны 90 хувийг Монгол улсын Засгийн газар эзэмшдэг, 10 хувийг нь бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Монгол улсын Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК “Шивээ Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны төрийн төлөөллийг хэрэгжүүлж байна.




Орд нь зүүн хойноосоо баруун урагшаа сунаж тогтсон уртаараа 35 км өргөнөөрөө 15 км хэмжээтэй Шинэ-Ус, Өехийн цагаан, Ногоон тойрмын гэсэн 3 хэсгүүдээс бүрдэнэ. Шивээ Овоо ХК, Эрдэнэс Монгол нэгдлийн нийт 4290 га талбайд 594.2 сая.тн нүүрсний нөөцтэй.

## КОМПАНИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

"Шивээ Овоо" ХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн  
А/116 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

"ШИВЭЭ ОВОО" ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



Манай компани Гүйцэтгэх захирлын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/116 дугаар тушаалаар дараах бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд: Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан тэргүүн дэд захирал, Бизнес хөгжил хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал, Ерөнхий инженер болон 5 хэлтэс, 3 алба, 7 хэсэг гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулсан байна.

Компанийн захирлын зөвлөл тайлант онд 22 удаа хуралдаж нийт 294 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Шивээ Овоо ХК нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 435 ажилтантайгаар үйл ажиллагаагаа гүйцэтгэж байна. Үүнээс:

Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээгээр 430,

Хүүхэд асрах чөлөөтэй 3,

Хугацаат цэргийн албанд татагдсан 2

### Ажилтнуудын ажил, албан тушаалын зэрэглэл:

Удирдлага 3

Инженер техникийн ажилтан 75

Мэргэжилтэн 28

Ажилтан 329

Тайлбар: Компани ажлын шаардлагаар 9 иргэнийг хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж болно. Үүнээс эмэгтэй 4, эрэгтэй 5 ажилтан.

Хөдөлмөрийн гэрээ байгуулсан 93 ажилтнаас 72 ажилтан буюу 77 хувийг орон нутгийн иргэд эзэлж байна.

**Ажилтнуудын насны байдлыг харуулахад:**

№	Нас	Тоо		Нийт	Хувь
		Эрэгтэй	Эмэгтэй		
1.	18-25	50	2	52	12%
2.	26-35	104	24	128	29,4%
3.	36-45	126	31	157	36,1%
4.	46-аас дээш	81	17	98	22,5%
<b>Нийт</b>		<b>361</b>	<b>74</b>	<b>435</b>	<b>100%</b>

Ажилтнуудын дундаж нас: **38** нас

**Хүйсийн байдлаар нь авч үзвэл:**

№	Хүйс	Тоо	Хувь
1.	Эрэгтэй	361	83%
2.	Эмэгтэй	74	17%

**Боловсролын түвшнээр нь авч үзвэл:**

№	Ангилал	Тоо	Хувь%	
1.	Боловсролгүй	-		
2.	Бага боловсролтой	2	0,5	
3.	Суурь боловсролтой	10	2,3	
4.	Бүрэн дунд	10	2,3	
5.	Мэргэжлийн болон техникийн	271	62,3	
6.		142	32,6	
7.	Дээд			Дипломын-18
8.				Бакалавр-115
		Магистр-9		
<b>Нийт</b>		<b>435</b>	<b>100</b>	

Зөвлөх инженер-1, Мэргэшсэн инженер-6

**Ажилтнуудын тогтвор суурьшил, ажилласан жил:**

№	Ажилласан жил	Тоо	Хувь
1.	1 – 4	173	39,8%
2.	5 – 10	101	23,2%

3.	11- 15	68	15,6%
4.	16 – 20	60	13,8%
5.	21-ээс дээш жил	33	7,6%
<b>Нийт</b>		<b>435</b>	<b>100%</b>

### **Бичиг хэрэг**

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар  
 Ирүүлсэн албан бичиг-516,  
 Явуулсан албан бичиг-823,  
 Эрх бүхий дээд газраас ирсэн албан бичиг-172,  
 Хариутай-95 албан бичгүүдэд тус тус дугаар өгч, бүртгэл хөтлөн холбогдох албан тушаалтанд шилжүүлж, баримт бичгийн бүрдэл хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.  
 2024 онд нийт 524 тушаал төлөвлөн батлуулсан болно. Үүнд:  
 оУдирдлага зохион байгуулалтын чиглэлээр А тушаал-101,  
 оХүний нөөцийн чиглэлээр Б тушаал-423 тушаал  
 Хүний нөөцийн Б тушаалаас ажилд орсон, ажлаас чөлөөлсөн, ажлын байр өөрчлөгдсөн, сахилгын шийтгэлийн тушаалыг хувилж ажилтны анкетыг баяжуулан хийж байна.

### **2024 оны КОМПАНИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС**

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөлт, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, уулын ажлын бүхий л үзүүлэлтүүдийг дунджаар 110%-ийн биелэлттэй ажилласан.
- Манай уурхай нь жилийн хугацаанд 2.63 сая.тн нүүрс олборлон, борлуулж 11.0 сая.м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэсэн нь уулын ажлын түүхэн дээд үзүүлэлтийг шинэчлэн тогтоосон.
- Түүхэндээ хамгийн олон тэсэлгээний ажил буюу 365 хоногт 542 удаагийн өрөмдлөг, тэсэлгээний ажил гүйцэтгэсэн.
- Монгол улсын эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, вагон ачилтын хоногийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагын хүрээнд 586м урттай, нэг цуваандаа 20 вагон ачих дагнасан хэрэглээний салаа төмөр замыг барьж ашиглалтад оруулсан.
- Нүүрсний шинжилгээний лаборатори MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлага дагуу Үндэсний итгэмжлэлийн төвөөс давтан итгэмжлэгдсэн.
- Тусгай хамгаалалттай “Чойрын Богд” ууланд зэрлэг ан амьтан ундаалах хөв цөөрөм байгуулсан.
- Уурхайн ашиглалт явуулж буй ордын шинэ усны хэсэгт олон улсын “JORC” стандартад нийцсэн геологи хайгуулын ажлыг эхлүүлсэн.
- 2023 оны 1 дүгээр сараас эхлэн Санхүүгийн зохицуулах хороо “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх болсон. Энэхүү үнэлгээг хагас жилд нэг удаа хийдэг ба 3 удаагийн үнэлгээгээр “Шивээ Овоо” ХК дараах байдлаар үнэлэгдсэн байна.
- Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд жилийн үйл ажиллагааны үзүүлэлтээр 2023 онд өртөг зарлагаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэн удирдлагын манлайллыг сайн хэрэгжүүлж компанийн эдийн засгийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн хамгийн өндөр түвшинд хүргэсэн амжилтаар “Эрдэнэс Монгол нэгдлийн 2023 оны менежментийн үйлчилгээг сайн хэрэгжүүлэгч компани”-аар шалгарч 100,0 сая

төгрөгийн шагнал авсан бөгөөд энэхүү шагналын сангаараа **Фитнес, иогийн** шинэ барилгыг бүтээн байгуулсан.

➤ 2024 оны нийт хөрөнгө оруулалтын 25,6 тэрбум төгрөгийн 17,3 тэрбум буюу 68%-ийг санхүүжүүлсэн байна. Үүнд Технологийн автосамосвал CAT773E 2ш, Гидроэкскаватор CAT350 1ш, Авто ачигч SEM956 2ш, Уурхайн зориулалттай гар станц 70ш, Тэсэлгээний ачааны машин 5 тонн 1ш, Дотоод түлш тээврийн машин 5-8 тонн 1ш, Үйлчилгээний авто машин FORD RANJER XLT 1ш.

➤ 2024 оны компанийн засаглалын үнэлгээний тайлангаар компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч топ 20 компанийг нэрлэсэн ба “Шивээ Овоо” ХК 90.2 хувийн үнэлгээгээр 16-д жагсаж энэхүү топ 20 компанид багтсан бөгөөд 2024 онд тус компани нь **КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭГЭЭР ТОП 20 КОМПАНИЙН НЭГЭЭР ШАЛГАРЛАА.**

## ХОЁР: ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### УУЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

2024 онд 2630.0 мян.тн нүүрс олборлон борлуулах нь уурхайн хүчин чадлаас 31.5%-иар давсан ажил болж байгаа бөгөөд төлөвлөгөөнд тодотгол хийж Эрдэнэс Монгол Нэгдэлд, ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж ажиллав.

Нэмэлт захиалгатай холбоотой хийгдэх уулын ажилд шаардлагатай ТЗБАХ-г авч хэрэгжүүлэхэд төлөвлөгөөнд тодотгол оруулах, тендер зарлах зэрэг хугацаа шаардсан ажлууд их байсан.

“2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажил”-ын хүрээнд Их засварын 10, ТЗБАХ /Ус хангамж -2, барилга байгууламж -3, ТТ-ийн бэлэн байдлыг хангах -17, бусад-2/ 24 буюу нийт 34 ажил төлөвлөн ажиллаж, 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар өвөлжилтийн бэлтгэл ажлын гүйцэтгэл 100%-тай байгаа бөгөөд Тодотгол төлөвлөгөөний дагуу нэмэлтээр хийгдэж байгаа 3 чиглэлийн /Цахилгаан хангамж - 3, Дулаан хангамж -3, бусад -1/ нийт 7 ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

### Уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Х.н	2023 он мөн үеийн гүйцэтгэл	2024 оны Гүйцэтгэл				2023 оны мөн үетэй харьцуулсан		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+, - /	%	Зөрүү/ +, - /	%	
Нүүрс гаргалт	м.тн	2479.1	2400.0	2633.3	233.3	109.7	154.2	106.2	
Нүүрс борлуулалт	м.тн	2477.5	2380.0	2623.6	243.6	110.2	146.1	105.9	
<b>Нийт хөрс хуулалт</b>	<b>м.м3</b>	<b>10097.8</b>	<b>9890.0</b>	<b>11151.3</b>	<b>1261.3</b>	<b>112.8</b>	<b>992.9</b>	<b>110.4</b>	
Үүнээс	Тээвэртэй хөрс	м.м3	8109.2	7840.0	9484.2	1644.2	121.0	1314.4	117.0
	Тээвэргүй хөрс	м.м3	1988.6	2050.0	1667.1	-382.9	81.3	-321.5	83.8
<b>Уулын цул</b>	<b>м.м3</b>	<b>12146.6</b>	<b>11873.5</b>	<b>13327.5</b>	<b>1454.1</b>	<b>112.2</b>	<b>1120.4</b>	<b>109.7</b>	
Дахин шидэлт	м.м3	3258.4	3340.0	3558.6	218.6	106.5	300.2	109.2	
Инженер ажил	м.м3	781.7	1666.4	1649.1	-17.3	99.0	867.4	211.0	
Үүнээс	Автын	м.м3	208.8	545.0	714.4	169.4	131.1	505.6	342.2

	Автын бус	м.м3	572.9	1121.4	934.7	-186.7	83.3	361.8	163.1
<b>Нийт гүйцэтгэсэн ажил</b>		<b>м.м3</b>	<b>16186.7</b>	<b>16879.9</b>	<b>18535.2</b>	<b>1655.4</b>	<b>109.8</b>	<b>2288.0</b>	<b>114.5</b>

Тайлангийн хугацаанд 2400.0 мян.тн нүүрс олборлон, 2380.0 мян.тн борлуулах, 9890.0 мян.м3 хөрс хуулах үүнээс тээвэртэй 7840.0 мян.м3, тээвэргүй 2050.0 мян.м3-ын төлөвлөгөөтэй ажилласнаас нүүрс олборлолт 2633.3 мян.тн, борлуулалт 2623.6 мян.тн, нийт хөрс 11151.3 мян.м3 үүнээс тээвэртэй 9484.2 мян.м3, тээвэргүй 1667.1 мян.м3 хөрсний ажил тус тус гүйцэтгэсэн байна.

2024 оны эхнээс хэрэглэгчдээс ирүүлсэн нүүрсний нэмэлт 250.0 мян.тн нүүрсийг олборлон борлуулах шаардлагаар техник зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч хур бороо, үер усны давтаж их, ажлын бус хажуугийн гулсалтын идэвхжилт, нүүрсний чанар зэрэг хүндрэлтэй нөхцөл байдлаас хамаарч ашиглалтын 2-р аманд ЭШ-25/90 алхагч экскаваторын ажлын талбайд цлик тулгуур үлдээж, 120.0 мян.тн нүүрс нээх ажлыг 2025 онд 1-р улиралд хийхээр төлөвлөсөн ашиглалтын 3-р амны зүүн жигүүрийн гарш хэсгийн 155.0 мян.тн нүүрсийг урьдчилан нээхээр шилжүүлэн ажлыг эхлүүлсэн.

2023 оны 185.0 мян.тн нүүрсний нэмэлт захиалгыг хангах ажлын хүрээнд 770.0 мян.м3 тээвэртэй хөрс хуулахаас гүйцэтгэлээр 482.1 мян.м3-ийг 2024 онд шилжүүлэн хийж, нүүрсний нөөц, борлуулалтыг ханган ажилласан. Тус ажлын хүрээнд 2024 оны ХБГ-ээр нүүрсний нэмэлт захиалгатай холбоотой зайлшгүй хуулах шаардлагатай тээвэртэй хөрс хуулалтын ажлын төлөвлөгөө 519.2 мян.м3-ээр давсан үзүүлэлт гарч байгаа ч нүүрсний шилжих нөөц шаардлагатай хэмжээнд нэмэгдээгүй ба карьерт чийг багатай 20.0 мян.тн, устай буюу чийг өндөртэй 60.0 мян.тн, нүүрсний агуулахад 27.2 мян.тн тус тус шилжиж байна.

**Борлуулсан нүүрсний чанар:** 2024 оны гүйцэтгэлээр I давхаргын нүүрс 1537.6 мян.тн, II, IIa, V давхаргын нүүрс 1096.0 мян.тн нийт 2633.3 мян.тн нүүрс олборлон, хэрэглэгчид 2623.5 мян.тн нүүрс борлуулсан байна. Тус хугацаанд уурхайн зүүн жигүүрт олборлосон нүүрс нь завсрын хөрсний үе ихтэй, салаалсан тогтоцтой, чанарын хувьд бага үзүүлэлттэй. Ашиглалтын 3-р ам хайгуулын XI-XIII шугам хооронд MV-013311 тусгай зөвшөөрлийн талбайд хамрах II давхаргын 27B, 31C блокуудын нүүрс нь завсрын хөрсний үетэй тул чанарын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж нүүрс бохирдуулагч хар шавар, шавран-цар, бор саарал өнгийн аргилитын линз үеүдийг нүүрсний давхаргын 0.6 метрээс дээш нүүрсний үеүдийг чанарын хувьд хэрэглэгчид нийцэх нүүрсийг гидроэкскаватораар ангилан ялгаж хаягдал маш багтайгаар олборлон борлуулсан.

Үзүүлэлт	Чийглэг %	Үнслэг %	Илчлэг ккал/кг
Төлөвлөгөө	42.0	7.2	3000
Гүйцэтгэл	42.8	9.3	2950
Зөрүү	0.8	2.1	-50

**Хаягдал бохирдолт:** 2024 оны гүйцэтгэлээр уулын ахилтад өртсөн геологийн нийт нөөц 2791.8 мян.тн, ашиглалтын нөөц 2633.3 мян.тн нүүрс олборлон борлуулсан. Үүнээс I давхаргын нүүрс 1537.6 мян.тн, II давхаргын 1096.0 мян.тн, нүүрс олборлосон биелэлттэй байна. Ашиглалтын 1, 2, 3-р амны хайгуулын IX-XIII дугаар шугам хооронд олборлолт явуулахад 2-р давхарга нь 0,2-6,5 м зузаантай 7-8-н элсэн чулуу, аргиллит,



алевролит, нүүрслэг алевролит, приттэй нүүрс шавар зэргийн чулуулгийн олон үетэй учраас ангилан ялгахад хайгуулын VII-X дугаар шугамын хооронд зүүн тийш суналын дагуу 1986 оны хайгуулын цооногийн мэдээлэл дээр байхгүй шаврын 5 судал лийнз үеүд гарч ирснээр бохирдол үүсэж ангилан ялгаж ажиллаж байна. Зүүн жигүүр ашиглалтын 3-р ам, суналын дагуу XI-XIII хооронд олборлолт явуулах 2-р давхарга нь 0.2-6 м зузаантай 8-9 чулуулгийн линз үетэй учраас 2-р давхаргын нүүрсний үеүдийг гидроэкскаватораар ангилан ялгаж олборлохоор төлөвлөсний дагуу 2024 онд нийт уурхайн хэмжээнд 158.5 мян.тн буюу 6.0% нүүрсний хаягдалтай, 11.0 мян.тн буюу 0.5 %-ийн бохирдолттой гүйцэтгэсэн байна. ЭШ-25/90, ЭШ-11/70 алхагч экскаваторуудаар нүүрсний давхаргуудын ажлын бус талын заагийг гаргаж ханыг цэвэрлэж ажилласан.

**Гүний ус шүүрүүлэлт:** Уурхайн үйл ажиллагааг саадгүй явуулахын тулд гүний усны түвшинг нүүрсний давхаргаас доош барих шаардлагатай бөгөөд уурхайн гүн гүнзгийрэх тусам гүний усыг зайлуулахад хүндрэл гарч байна.

Ус шүүрүүлэх нь 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар В, С, 16, D шугам болон карьерийн ЦНС насосууд жилийн дунджаар нийт 39 худаг ажиллаж, 3153.6 мян.м3 ус уурхайгаас шавхан зайлуулж, усны түвшинг -1.0 м-ээр бууруулахаар төлөвлөснөөс нийт 26 худаг ажиллаж 66.0 %-тай, баталгаажсан худгийн тоолуурын заалтаар 837.3 мян.м3 ус уурхайгаас зайлуулж биелэлт 25.0 %-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Хяналтын цооногуудын дунджаар оны эхнээс 1126.68м – 1125.98м түвшинд -0.70 м-ээр буурсан байна.

Тус хугацаанд ус шүүрүүлэхийн төлөвлөгөөнд ашиглалтын D47, D48, D49 ширхэг цооног 368 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулахаас ашиглалтын D47, D48, D49 дугаартай 3 ширхэг цооног 368 уртааш метр өрөмдөж монтажлан ашиглалтад оруулсан. D47, D48, D49-р худгийн салбар шугамын 1.2 мян.м3 хөрсөөр салбар шугамын хучилтын далан байгуулан шугам хоолойн хучилт хийж хэлбэршүүлсэн.

Хяналтын цооногуудын мэдээллээр карьерын усны түвшинг -12.50 м буулгасан ба карьерт нүүрс олборлолтын ажил гүйцэтгэсэн ашиглалтын 1, 2, 3-р аманд ил зумпфын аргаар насос байрлуулан усны түвшинг 16 м-ээр буулган устай 387.1 мян.тн, 310.6 мян.тн, 650.0 мян.тн, нийт 1347.7 мян.тн нүүрсийг усны хүндрэлгүй бүрэн олборлож чадсан.

**Өрөмдлөг, тэсэлгээний ажил:** 2024 оны байдлаар 2486.0 тн энгийн найрлагат тэсрэх бодис, 158.0 тн эмульсийн тэсрэх бодис зарцуулж, 202.0 мян уртааш метр өрөмдөн 7085.1 мян.м<sup>3</sup> уулын цулыг тэсэлж сийрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр 23021 ширхэг цооногийг 180.8 мян уртааш метр өрөмдөж, 7035.9 мян.м<sup>3</sup> уулын цулыг 120мм-ийн диаметртай 145.6 тн эмульсийн тэсрэх бодис, 2097.2 тн задгай энгийн найрлагат тэсрэх бодис зарцуулан 542 удаагийн тэсэлгээгээр тэсэлж сийрэгжүүлсэн байна. Мөн нүүрсний тэсэлгээний ажилд 32мм-ийн диаметртай 5.3тн эмульсийн тэсрэх бодисыг өдөөгчийн зориулалтаар зарцуулсан.

Үзүүлэлт	Уулын цул /мян.м3/			Уртааш метр /мян.м/			ЭНТБ /тн/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Тээвэргүй хөрс	1230.0	1026.4	-203.6	25.8	20.4	-5.4	467.4	324.1	-143.3
Тээвэртэй хөрс	4665	5112.1	447.1	134.4	131	-3.4	1599.5	1575.7	-23.8

<b>Нүүрс гаргалт</b>	1190.1	897.4	-292.7	41.7	29.4	-12.3	419.1	197.4	-221.7
<b>Нийт</b>	<b>7085.1</b>	<b>7035.9</b>	<b>-81.9</b>	<b>202</b>	<b>180.8</b>	<b>-21.2</b>	<b>2486</b>	<b>2097.2</b>	<b>-434.5</b>

Нийт 202.0 мян.уртааш метр өрөмдлөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 25.8 мян.у.м, тээвэртэй хөрс хуулалтад 134.4 мян.у.м, нүүрс олборлолтод 41.7 мян.у.м өрөмдлөг гүйцэтгэх төлөвлөгөөтэй ажилласан.

Гүйцэтгэлээр нийт 180.8 мян.у.м буюу 89.5%-ийн биелэлттэй ажилласан. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 20.4 мян.у.м буюу 79.0%, тээвэртэй хөрс хуулалтад 131 мян.у.м буюу 97.4%, нүүрс олборлолтод 29.4 мян.у.м буюу 70.5%-ийн тус тус биелэлттэй ажилласан байна.

#### **Сийрэгжүүлэх уулын цул:**

Нийт 7085.1 мян.м3 уулын цулыг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлэн ухаж ачихад бэлтгэхээр төлөвлөсөн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 1230 мян.м3, тээвэртэй хөрс хуулалтад 4665 мян.м3, нүүрс олборлолтод 1190.1 мян.м3-ийн уулын цулын тус тусын төлөвлөгөөтэй ажилласан.

Гүйцэтгэлээр нийт 7035.9 мян.м3 уулын цулыг өрөмдлөг тэсэлгээний ажлаар бутлан сийрэгжүүлж 99.3%-ийн биелэлттэй ажилласан. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 1026.4 мян.м3 буюу 83.4%, тээвэртэй хөрс хуулалтад 5112.1 мян.м3 буюу 109.5%, нүүрс олборлолтод 897.4 мян.м3 буюу 75.4%-ийн тус тус биелэлттэй ажилласан байна.

#### **Тэсрэх материалын зарцуулалт:**

2024 оны байдлаар 2486 тн ЭНТБ, 158 тн усанд тэсвэртэй савлагаат эмульсийн тэсрэх бодисоор уулын цулыг тэслэн сийрэгжүүлэхэд тэсрэх бодисын хувийн зарцуулалтыг дунджаар 0.36 кг/м3 байхаар тооцоолон төлөвлөсөн. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 467.4 тн, тээвэртэй хөрс хуулалтад 1575.7 тн, нүүрс олборлолтод 419.1 тн ЭНТБ, мөн усны ундаргатай I давхаргын нүүрсний тэсэлгээний ажилд 152 тн эмульсийн тэсрэх бодисыг цочир дамжуулах шижим /ДШН-6, ДШЭ-12/ болон нонель системийн цахилгаан бус тэсэлгээний хэрэгсэлтэй хослуулан ашиглахаар төлөвлөсөн.

2024 оны гүйцэтгэлээр нийт 2097.2 тн ЭНТБ-ыг 0.32 кг/м3, 145.6 тн эмульсийн тэсрэх бодисыг 0.29 кг/м3 хувийн зарцуулалттайгаар тус тус зарцуулсан. Үүнээс тээвэргүй хөрс хуулалтад 324.1 тн буюу 69.3%, тээвэртэй хөрс хуулалтад 1575.7 тн буюу 98.5%, нүүрс олборлолтод 197.4 тн буюу 47.1%-ийн тус тус биелэлттэй ажилласан байна.

#### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

➤ Агаарын тоосжилт бохирдлыг бууруулахын тулд зам усалгааны 40-50 тн-ы даацтай TEREХ автомашин /2ш/ болон БНХАУ-ын “Dongfeng” үйлдвэрийн 10 тн-ы даацтай усны машинуудаар Уурхайн нутаг дэвсгэр дэх тоосжилт ихтэй зам, талбайг бороожуулан чийгшүүлж, туслах техникүүдээр тогтмол арчлан мод, бут, сөөг усалж байна.

➤ “Хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам”-ийн дагуу аваарын эмнэлгийн хогийг Шивээговь сумын Нэгдсэн эмнэлэгтэй хамтран гэрээ байгуулан /Аюултай хог хаягдлын журмын дагуу/ зайлуулах болон устгах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийт хэсэг нэгжүүдэд хог хаягдлын ангилан ялгалтын хогийн савыг байршуулж, нийт ажилчдад “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж, ангилан ялгаж хэвшье” дадлыг хэвшүүлэх зорилгоор зурагт хуудаснуудыг тарааж мэдээллийн самбарт байршуулав.

➤ Хөрс, газрын гадаргын хувьд төлөвлөгөөний дагуу уурхайн хэсэг нэгжүүд, мөн ШТС-ын ажилтнуудаар тус тус орчны цэвэрлэгээ хийлгүүлж, үүрэг даалгавар өгч ажилласан.

➤ Гүний болон гадаргын усны түвшингийн хэмжилтийн бүртгэл, мөн шахсан усны хэмжээг баталгаажуулалт хийгдсэн тоолуураар хянаж, бүртгэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.

➤ ХАБЭА-н хэлтэстэй сөрөг нөлөөллийг бууруулахаар дараах ажлуудыг хамтран гүйцэтгэсэн.

Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториор агаарын бохирдлын шинжилгээг 6,10 сард цэгээс дээж авч дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран Ажилчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

УЛААНБААТАР-ЗАМЫН ҮҮД чиглэлийн хатуу хучилттай авто замаас Уурхайн шалган нэвтрүүлэх пост-3 хүртэлх 4.9 км замыг сайжруулж, тоосжилтыг бууруулах арга хэмжээг тогтмол сайжруулж арчлаж байна.

Шалган нэвтрүүлэх пост-1-ээс ТДХ конвейер хүртэлх замыг 2 урсгалтай болгох ажлыг зохион байгуулж бүрэн тэмдэгжүүлсэн.

Уурхайн бүс доторх бүх талбай хамрагдах ба технологийн авто машинаас үүсэх хорт хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна.

#### Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

Уул ажлын төлөвлөгөөтэй уялдуулан уулын ахилт болон гадаад овоолгын тэлэлтэд өртөх талбайгаас шимт хөрс хуулж шимт хөрсний бэлтгэгдсэн агуулах болон техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 4 га талбайд тээвэрлэн буулгаж тэгшилж хэлбэржүүлэн биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж арчилгаа тордлогоо тал дээр Технологийн бодлогын хэлтсийн зүгээс нөхөн сэргээлтийн гэрээт ажилтан 4 хүнийг ажлын байраар ханган амжилттай гүйцэтгэн. Говьсүмбэр аймгийн БОГазрын ажлын хэсэгт 12-р сарын 23 өдөр нөхөн сэргээлтийн ургалт 90 %-тай маш сайн үнэлгээтэйгээр хүлээлгэн өгч хамтран ажилласан.

Хүрээлэн буй орчныг хамгаалах нөхөн сэргээх, асуудлыг төлөвлөгөөний дагуу үр дүнтэй зохион байгуулж хавар 5000ш мод тарьж ургалт 93 %-тай ургасан. Намар 15000ш мод тарьж цэнэг усалгааг хийж дууссан.

#### Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангийн дүйцүүлэн хамгаалах зорилт, чиглэлд тусгагдсан үйл ажиллагааны 2.2-д Биотехникийн арга хэмжээний 2.2.1., 2.2.3.-д тусгагдсан ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн Байгаль орчны газрын дарга, холбогдох мэргэжилтэн нартай зөвшилцсөний дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт /L-49-49/ орших Чойрын богд уулын зүүн урд талын аманд зэрлэг амьтдын усан хангамжийг сайжруулах зорилгоор тохиромжтой байршилд “Хөв цөөрөм” байгуулах, Ламын худгийн эхийг хамгаалан тохижуулж засварлах аэеё гүйцэтгэнэ гэсний дагуу “хөв цөөрөм” байгуулж талбайд хийгдсэн цөөрмийн газар шорооны ажил, талбайг тэгшлэх, мембран дэвсэж бетон

зуурмагийг 0.10 метр зузаантайгаар тарааж цутгаж дүүргэн 13х16 харьцаатай хөв цөөрөм үүсгэж фото зураг болон маркшейдерийн хэмжилт хийж дэвсгэр зурагт буулгав.

## **ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТЕХНИК ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР**

2024 оны 4-р улиралд технологийн автосамосвал, хүнд машин механизм, технологи дамжлага, цахилгаан экскаватор, тэсэлгээний өрөмдлөгийн механизмуудын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус засвар үйлчилгээг графикийн дагуу хийж уурхайгаар техникийн бэлэн байдлын коэффициент төлөвлөгөөгөөр ТАК-0,73 гүйцэтгэлээрээ ТББК-0,77 хувьтай ажилласан.

Сэлбэг материалын зардал 4-р дугаар улирлын төлөвлөгөөгөөр 2,3 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл 2,9 тэрбум төгрөгийн зардал гарсан. Хавсралтаар гүйцэтгэлийг хавсаргав.

1. Технологийн автосамосвалын засвар үйлчилгээнд нийт 16-19 техниктэй ажилласан. Төлөвлөгөөгөөр техникийн бэлэн байдлын коэффициент 0,70 хувьтай ажиллахаас ТББК- 0,72-тай ажиллаж байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Технологийн автосамосвал	HD465-7	0.62	0.57	0.65	0.63
		CAT773	0.70	0.65	0.70	0.69
		CAT777	0.99	0.91	0.99	0.97
		Бел137	0.71	0.62	0.54	0.51
		Дүн	0,76	0,69	0.72	0.70

Төлөвлөгөөт томоохон агрегат засварын ажил хийгдээгүй. /Тендер зарлагдсан, шалгаруулалт явагдаж байна./

Төлөвлөгөөт бус томоохон засвар үйлчилгээний ажилд

- CAT773 №19 автосамосвалын редукторт гэмтэл гарсан. Захиалга хийгдсэн, 33,0 сая төгрөгийн зардал гаргасан.
- CAT773 №20 автосамосвалын хөдөлгүүрийн крышка хагарсан гэмтэл гарсан. 63,0 сая төгрөгийн зардал гаргасан. Засварын ажил хийгдэж байна.
- БелА375137 №01 автосамосвалын турбины тос цацаж гэмтлийн дагуу 2ш шинээр 84,9 сая төгрөгийн зардал гаргаж засварласан.
- HD465-7 № 26, 29 гэрээний ажлын хөдөлгүүр засварын ажилд доголдол гарсан. Баталгаат хугацаанд сэлбэг захиалга хийж нийлүүлэлт удааширсан.
- CAT773 №21 автосамосвалын хөдөлгүүрт гэмтэл гарч томоохон эвдрэл гарсан. Төсөвт өртөг нэмэгдсэн.

2. Хүнд машин механизмуудын засвар үйлчилгээнд 4 техниктэй ажилласан. Төлөвлөгөөгөөр техникийн бэлэн байдлын коэффициент 0,75 хувьтай ажиллахаас ТББК- 0,60-тай ажилласан байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Хүнд машин механизм	TD25M №02	0.27	0.27	0.01	0.01
2		TD25M №03	0.02	0.02	0.82	0.82
3		TD25M №04	0.98	0.99	0.91	0.91
4		D8R	0.53	0.52	0.67	0.66
			0.45	0.44	0.60	0.60

Төлөвлөгөөт томоохон агрегат засварын ажил хийгдээгүй. /Тендер зарлагдсан, шалгаруулалт явагдаж байна./

- TD25M №02 бульдозер эргэх механизмын эд ангийн гэмтэл гарч, захиалга хийгдсэн боловч гадаад нөхцөл байдлаас шалтгаалан худалдан авалт хийгдээгүй болно. /Эргэхийн редукторын сальник, жийрэг/

Төлөвлөгөөт бус томоохон засвар үйлчилгээний ажилд

- D8R гинжит бульдозерын коробка араагүй болсон зэрэг засварын ажлыг хийсэн. Гарсан зардал 20,сая төгрөг.

3. Зам талбай түрэх, засах механизмын хувьд 2-1 техниктэй ажилласан. Төлөвлөгөөгөөр техникийн бэлэн байдлын коэффициент 0,65 хувьтай ажиллахаас ТББК- 0,44-тай ажилласан байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Зам талбай засах механизм	SEM922 №01	0.00	0.00	0.00	0.00
2		SEM922 №02	0.01	0.01	0.88	0.74
Нийт дүн			0.44	0.44	0.44	0.37

- SEM922 №01 автогрейдер гал гарсан шалтгааны улмаас сэргээн засварлахад шаардлагатай сэлбэг материал хүлээгдэж байна.
- Зам талбай сайжруулах үүднээс түрээсээр хүчин чадал өндөртэй САТ техникийн автогрейдер түрээслэж, зам талбайг сайжруулж ажилласан.

7. Ухаж ачих техникүүдийн хувьд төлөвлөгөөгөөр техникийн бэлэн байдлын коэффициент 0,75 хувьтай ажиллахаас ТББК- 0,93-тай ажилласан байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Ухаж, ачих механизмууд	PC1250 №03	0.90	0.87	0.92	0.91
		PC1250 №04	0.98	0.95	0.98	0.98
		CAT345D	0.96	0.52	0.83	0.83
		DX500	0.71	0.66	0.79	0.76
		CAT350 №01	1.00	1.00	0.99	0.99
		CAT350 №04			1.00	1.00

		CAT395 №01			1.00	1.00
Нийт дүн			0.91	0.80	0.93	0.91

Төлөвлөгөөт томоохон агрегат засварын ажил хийгдээгүй. /Тендер зарлагдсан, шалгаруулалт явагдаж байна./

Төлөвлөгөөт бус томоохон засвар үйлчилгээний ажилд

- DX500 гидро экскаваторын хөдөлгүүрийн гэмтэж, хэсэгчлэн засвар үйлчилгээ хийхээр төлөвлөж байна.
- CAT345D гидро экскаваторын хөдөлгүүрээс металл үртэс гарч хөдөлгүүр гэмтэж зогссон.
- PC1250 №03 гидро экскаваторын хөдөлгүүрийн форсунка гэмтэж, шинээр сольж найдвартай ажиллагааг хангаж ажилласан. 18,0 сая төгрөгийн зардал гарсан.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу нүүрс гаргалт, завсрын хөрс, нүүрс ангилан ачих 3.6м3 шанаганы багтаамжтай гидро экскаватор 1 худалдан авсан.

5. Дугуйт ачигчийн хувьд төлөвлөгөөгөөр техникийн бэлэн байдлын коэффициент 0,75 хувьтай ажиллахаас ТББК-0,72 хувьтай ажилласан байна.

Д/д	Тонг төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Ухаж ачих механизм	DL550	0.01	0.01	0	0
		ZL50	0.66	0.64	0.46	0.44
		SEM653	0.46	0.45	0.61	0.61
		SHANMON 956-01	0.99	0.97	0.98	0.98
		SHANMON 956-02	0.97	0.97	0.98	0.98
		L-955HE			0.99	0.99
		L-975HE			1.00	0.99
Нийт дүн			0.62	0.62	0.72	0.71

Төлөвлөгөөт томоохон агрегат засварын ажил хийгдээгүй. /Тендер зарлагдсан, шалгаруулалт явагдаж байна./

Төлөвлөгөөт бус томоохон засвар үйлчилгээний ажилд

- DL550 дугуйт ачигчийн коробка эвдэрч шаардлагатай ашиглалтаас түр зогсоосон.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу вагон ачилтыг хэвийн ачих үүднээс 6-6,7м3 шанаганы багтаамжтай авто ачигч худалдан авсан.

6. Зам усалгааны автомашин техникийн бэлэн байдлын коэффициент 0,75 хувьтай ажиллахаас ТББК-1.00 хувьтай ажилласан байна.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Зам усалгааны машин	TEREX TR50	0.70	0.64	1.00	0.88
		TEREX TR60	0.19	0.17	1.00	0.88
Нийт дүн			0.24	0.24	1.00	0.88

Төлөвлөгөөт томоохон агрегат засварын ажил хийгдээгүй. /Тендер зарлагдсан, шалгаруулалт явагдаж байна./

Төлөвлөгөөт засвар үйлчилгээний ажилд

Зам усалгааны машины өвлийн улиралтай холбогдуулан урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.

7. Вагон ачилтын дамжлага, шулуун конвейер, богино конвейерийн бэлэн байдлыг хангаж 92 хувь хангаж ажилласан.

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк төрөл	3-р улирал		4-р улирал	
			ТББК %	ТАК %	ТББК %	ТАК %
1	Вагон ачилтын хэсэг	Технологи дамжлага	0.99	0.97	0.99	0.92
2		Шулуун конвейер	0.85	0.50	0.71	0.35
Нийт дүн			0.93	0.65	0.92	0.74

Төлөвлөгөөт засвар үйлчилгээг ажлын ачаалалаас шалтгаалан хийгдээгүй.

- 11 дугаар сард гулсалтаас шалтгаалан А конвейерийн ремонд гэмтэл гарч 4 хоногийн зогсолт авч 540 метр ремен сольж ажилд оруулсан. Үүнээс 176 метр ременийг шинээр сольж, үлдэгдлийн хуучин ременээр орлуулж хийсэн. Гарсан зардал ,0 сая төгрөг
- Гулсалтаас шалтгаан 7 хоногт 2 удаа шилжүүлэн өргөлт хийж байна.
- Решотик бэхэлгээ гагнуурын ажилбар солих ажлыг хийсэн.

8. Цахилгаан экскаватор 7 нэгж, 2 нэгж өрмийн машины урсгал засварын төлөвлөгөө боловсруулж батлуулан төлөвлөгөөт хугацааны дагуу засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

**Нэг.** ЭШ-25/90 алхагч экскаваторын сарын урсгал засварыг 3 удаа хийж гүйцэтгэсэн.

Засвар хийсэн хугацаа: 10/01-10/04, 11/07-11/11, 12/04-12/07-ний

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

ЦТТ-нд үзлэг хийж, шаардлагатай генераторын щётка, щётка баригч шинээр сольсон.

- Өргөхийн ф-70мм 500 метр тросс шинээр сольж найдвартай ажиллагааг хангасан.
- Өргөхийн редуктор, хийн системд үйлчилгээ хийсэн.
- 10-р сарын 1-ээс 10-р сарын 4 хүртэл нөөц шанага солих засварын ажлыг хийсэн.
- 10-р сарын 3-наас 10-р сарын 4 хүртэл ээлжийн үзлэгээр гидрийн шингэн гоожиж байгаа шалтгааныг олж тодорхойлж үндсэн цилиндрийн шпилка гайка чангалгаа хийсэн.

- 11-р сарын 7-ноос 11-р сарын 8 хүртэл өргөхийн зүүн талын хөдөлгүүрийн якорийн гол хугарсан томоохон эвдрэл гарч зогсож, нөөц засварласан якорь тавьж ажилд оруулсан.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 10-р сарын 11-нээс 10-р дугаар сарын 13 хүртэл тягын генератор гэмтэж, нөөц генератор сольж ажилд оруулсан.

**Хоёр.** ЭШ-11/70 алхагч экскаваторын сарын урсгал засварыг 1 удаа хийж гүйцэтгэсэн.

Засвар хийсэн хугацаа: 10 сар зогсолт байхгүй

11/18-11/20-ны өдөр хүртэл

12/11-12/13-нд ажлын шаардлагаар засвар хойшлуулсан.

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Цахилгаан тоногуудад үзлэг үйлчилгээ хийж пеналуудыг үлээлгэж цэвэрлэсэн
- Хөдөлгүүр генераторуудад үйлчилгээ хийж щётка, щётка баригч шинээр сольсон.
- Шанаганы цууралт өгсөн хэсэгт гагнуурын ажил хийгдсэн
- Тягын цепь сэргээн засварлаж гагнуурын ажил хийсэн
- Эргэх редукторт чангалгаа хийсэн
- Баз болон кузовны цууралт өгсөн газруудад гагнуурын ажил хийгдсэн

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 10-р сарын 8-нд венец арааны 3 шүд хугарч томоохон эвдрэл гарч зогссон. Хугарсан шүдийг сэргээн засварлах ажлыг 10-р сарын 15 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн. Цаашид хэвийн найдвартай ажиллуулах үүднээс шинээр венец араа, бегушийн араа солих шаардлагатай байна.
- 11-р сарын 18-нд II-р ээлж тягын редукторын 1-р голны холхивч нурж тягийн гол хөдөлгүүр шинээр тавьсан /2 удаа 11-р сарын 20 ахин нурсан/
- 11-р сарын 26-нд өргөхийн редукторын 1-р гол холхивч нурж зогссон
- 12-р сарын 21-ны I-р ээлж төв цапф хугарч томоохон эвдрэл гарч зогссон. Солих төв цапф байхгүй улмаас ажилд оруулах боломжгүй тул нэн яаралтайгаар шинээр худалдан авах шаардлагатай болсон. Засварын ажил төв цапф ирэх хүртэл хийгдэх болно.

**Гурав.** ЭКГ-10И экскаваторын сарын урсгал засварыг 1 удаа хийж гүйцэтгэсэн.

Засвар хийсэн хугацаа: 10/01-10/08 зогсолт байхгүй

11/11-11/13-ны

12/16-12/18- ажлын шаардлагаар засвар хойшлуулсан.

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Напорын хөдөлгүүр авч үйлчилгээ хийсэн.
- Засов, петухд наплавка тавьж гагнуурын ажил хийсэн.
- Эргэхийн редукторын чангалгаа хийж, хийн системд үзлэг хийсэн.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 10-р сарын 13-ны II-р ээлж компрессорын арьс хагарч зогсож, сэргээн засварлах ажлыг хийж 10-р сарын 14 ны I-р ээлжээр ажилд оруулсан.
- 12-р сарын 16-нд 5ш шүд сольсон



- 12-р сарын 23-нд өргөхийн тросс ф45,5мм 120 метр тросс сольж найдвартай ажиллагааг хангасан.

**Дөрөв.** ЭКГ-5А №01 экскаваторын сарын урсгал засварыг 1 удаа хийж гүйцэтгэсэн.

Засвар хийсэн хугацаа: 10/14-10/16-ны хүртэл

11/23-11/25 ажлын шаардлагаар засвар хойшлуулсан

12/18-12/12 ажлын шаардлагаар засвар хойшлуулсан

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Өргөхийн генератор авч үзлэг үйлчилгээ хийсэн.
- Шанаганы түгжээ, пятаханд гагнуурын ажилбар хийгдсэн.
- Хийн компрессорын суурь шинээр сольсон.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- Гэнэтийн эвдрэл саатал гараагүй, тээврийн машин байхгүй шалтгаанаар сул зогсолт хийж байсан.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 12-р сарын 22-нд явахын хэвтээ редукторын 12 шүдтэй араа хугарч, шинээр сольж ажилд оруулсан.
- 12-р сарын 23-нд кремльярная араа шүд элэгдэн хугарч ашиглах боломжгүй бол яаралтайгаар худалдан авхуулж, 12-р сарын 28-нд шинээр кремльярная араа 2ш сольж ажилд оруулсан.

**Тав.** ЭКГ-5А №03 экскаваторын сарын урсгал засварыг 4 удаа хийж гүйцэтгэсэн.

Засвар хийсэн хугацаа: 10/01-10/03 11/01-11/03 12/02-12/04 12/16-12/20-ны өдөр

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ЦТТ-нд үзлэг үйлчилгээ хийж, хөдөлгүүр, генераторын щётка, щётка баригч шинээр сольж, панелуудын тоос шороог үлээлгэж цэвэрлэсэн.
- Засов,петух элэгдэлтэй хэсэгт гагнуурын ажилбар хийгдсэн.
- Коромыслын втулка,палец сольсон
- Үзлэг тосолгоо үйлчилгээ хийгдэж,эргэхийн 2 хөдөлгүүрийн улны холхивч тосолсон.
- Хийн системд техник үйлчилгээ хийсэн.
- Напороын хөдөлгүүр авч үйлчилгээ хийсэн
- Хуучин богино гол сольж тавьсан
- Коромыслын втулка, палец зоруулж шинээр сольж тавьсан
- Хуучин барабан угсарч тавьсан
- Элэгдэлтэй башмакны пальцуудыг сольж 1 ширхэг башмак шинээр тавьсан
- Хийн системд техник үйлчилгээ хийсэн.
- Стойканы шпилка 4ш зоруулж тавьсан
- Өргөхийн тросс сольж тавьсан /ЭШ11/70 актлагдсан тросс тавьсан/
- 1ш башмак шинээр сольсон.
- Өргөхийн генератор авч үйлчилгээ хийсэн
- Коромыслын втулка, пальц шинээр сольсон
- Өргөхийн богино гол шинээр сольж тавьсан
- Өргөхийн Z-109 m-18 араа шинээр сольж тавьсан

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 10-р сарын 3-ны I-р ээлж чиглүүлэгч мултарч зогссон. 10-р сарын 4-ны II-р ээлжээр гарсан
- 10-р сарын 23-ны I-р ээлж подъёмын хөдөлгүүрийн вентиляторын хөдөлгүүр шатаж зогссон

**Зургаа.** ЭКГ-5А №04 экскаваторын сарын урсгал засварыг 2 удаа хийж гүйцэтгэсэн

Засвар хийсэн хугацаа: 10/23-10/25 11/20-11/22 12/23-12/25- ажлын шаардлагаар засвар хойшлуулсан

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ЦТТ-нд үзлэг үйлчилгээ хийж, напорын генератор,напорын хөдөлгүүр авч үйлчилгээ хийж панелуудын тоос шороог үлээлгэж цэвэрлэсэн.
- Чиглүүлэгч дугуйны ган втулка ,гуулин втулка шинээр сольж тавьсан .
- Одон дугуй тосолгооны суваг бөглөрсөн байсныг сэтгэж засвар үйлчилгээ хийсэн.
- Башмакны пальц пальцууд сольсон.
- Коромыслын втулка, палец зоруулж шинээр сольж тавьсан.
- Элэгдэлтэй пальцуудыг шинээр сольсон.
- Чиглүүлэгч дугуйны элэгдэлтэй ган втулка ,гуулин втулка шинээр сольсон .
- Одон дугуйны гуяны втулка, голны втулка шинээр сольсон .
- Үзлэг тосолгоо үйлчилгээ хийгдсэн.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- Гэнэтийн эвдрэл саатал гараагүй, тээврийн машин байхгүй шалтгаанаар сул зогсолт хийж байсан.

**Долоо.** ЭКГ-5А №05 экскаваторын сарын урсгал засварыг 1 удаа хийж гүйцэтгэсэн

Засвар хийсэн хугацаа: 10-р сард Зогсолт байхгүй

11/09-11/11 ажлын шаардлагаар засвар хойшлуулсан

12/10-12/12-ны өдөр хүртэл

Засварын ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Цахилгаан тоноглуудад үзлэг үйлчилгээ хийж пеналуудыг үлээлгэж цэвэрлэсэн.
- Хөдөлгүүр генераторуудад үйлчилгээ хийж щётка, щётка баригч шинээр сольсон.
- Засов,петуханд наплавка тавьж гагнуурын ажилбар хийгдсэн.
- Коромыслын втулка, пальц шинээр сольсон.
- Явах механизмд үзлэг, тосолгоо үйлчилгээ хийсэн.
- Хийн компрессор шинээр сольсон.

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- 10-р сарын 13-нд өргөхийн богино голны шүд хугарч шинээр сольж ажилд оруулсан.

Техник ашиглалтын коэффициент: 2024 оны төлөвлөгөөгөөр цахилгаан экскаваторын ТББК-0,80% гүйцэтгэлээр 0,83%

№	Машин, техник			3-р улирал		4-р улирал	
	Нэр	марк	дугаар	ТББК	ТАК	ТББК	ТАК

1	Цахилгаан экскаватор	ЭКГ5А	№-01	0.46	0.38	0.84	0.80
2	Цахилгаан экскаватор	ЭКГ5А	№-03	0.75	0.46	0.75	0.58
3	Цахилгаан экскаватор	ЭКГ5А	№-04	0.43	0.37	0.91	0.80
4	Цахилгаан экскаватор	ЭКГ5А	№-05	0.87	0.56	0.81	0.77
5	Цахилгаан экскаватор	ЭКГ10И	№01	0.69	0.50	0.97	0.95
6	Алхагч экскаватор	ЭШ-25/90	№02	0.87	0.81	0.86	0.85
7	Алхагч экскаватор	ЭШ-11/70	№03	0.86	0.80	0.70	0.69
	<b>ДҮН</b>			<b>0.70</b>	<b>0.55</b>	<b>0.83</b>	<b>0.78</b>

9. ДМ-45, ДМ-30 өрмийн машины техник үйлчилгээнүүдийг мото цаг тутамд хийж гүйцэтгэж байсан. /250 мот/цаг, 500 мот/цаг, 1000 мот/цаг/

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

**Найм.** ДМ-45, ДМ-30 өрмийн машины техник үйлчилгээнүүдийг мото цаг тутамд хийж гүйцэтгэж байсан. /250 мот/цаг, 500 мот/цаг, 1000 мот/цаг/

Төлөвлөгөөт бус засварын талаар авч үзвэл:

- ДМ-45 өрмийн машин шинээр штанга сольсон мөн явахын катги солив. Явахын хөндлөн гол ханзарч гагнуурын ажил хийгдсэн. 11-р сард өрмийн кабины тавцан ханзарч шинээр хийж тавьсан.
- ДМ-45 өрмийн машин 12-р сарын 18-нд ажил гүйцэтгэж байх явцад баллоны соронзон шүүрээс шалтгаалан хийн компрессор тосгүй ажилласны улмаас халалт өгч ажиллахгүй боломжгүй болж зогсож засварын ажил хийж гүйцэтгэсэн.
- 11-р сард кардан гол хугарч, сэргээн засварлаж хийсэн боловч ахин хугарч шинээр худалдан авч сольж ажилд оруулсан.

Техник ашиглалтын коэффициент: 2024 оны төлөвлөгөөгөөр өрмийн машин төлөвлөгөөгөөр ТББК-0,73%, гүйцэтгэл ТББК-0,61%

№	Машин, техник			3-р улирал		4-р улирал	
	Нэр	марк	дугаар	ТББК	ТАК	ТББК	ТАК
1	Өрмийн машин	DM45E	№-02	0.75	0.68	0.53	0.42
2	Өрмийн машин	DM30 II		0.86	0.81	0.69	0.65
	<b>ДҮН</b>			<b>0.80</b>	<b>0.74</b>	<b>0.61</b>	<b>0.54</b>

#### ТББК-н үнэлгээ

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Үнэлгээний хэмжүүр	Авбал зохих оноо	Гүйцэтгэлийн хэмжүүр	Үнэлгээ аргачлал
Тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдал	-2024 оны 4-р улирлын зардал, сэлбэг, шатах тослох материал, ашиглалтын	5 оноо	-2024 оны ТББК-н	Хувь тэнцүүлэн тооцох аргачлалаар

коэффициентын биелэлт	үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн мэдээ, мэдээлэл, тайлан -2024 оны 4-р улирлын ТБК-н төлөвлөгөө хавсаргав. -2024 оны 4-р улирлын ТБК-н гүйцэтгэлийн мэдээ, мэдээлэл, тайлан хавсаргав.		төлөвлөгөө 75,0% Гүйцэтгэл 80,%	тооцож 5 оноо гарч байна.
-----------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	------------------------------------	---------------------------

## 2024 ОНЫ ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Төлөвлөгөө		Гүйцэтгэл /2025.03.31 байдлаар/			
		Тоо хэмжээ	Санхүүжих дүн /мян.төг/	Тоо хэмжээ	Гүйцэтгэл дүн /мян.төг/	Санхүүжсэн дүн /мян.төг/	Үлдэгдэл /мян.төг/
	1	2	4	5	6	7	7
1	Барилга, байгууламж	1	1,070,000.00	1	985,000.00	868,432.00	116,568.00
1.1	520м урттай салаа төмөр зам	1	1,070,000.00	1	985,000.00	868,432.00	116,568.00
2	Авто тээврийн хэрэгсэл	20	34,175,797.00	19	24,436,742.00	17,827,987.29	6,608,754.71
2.1	Автосамосвал САТ773D /55-60 тонн /нүүрс/	2	7,200,000.00	2	6,444,730.00	4,940,959.58	1,503,770.42
2.2	Автосамосвал САТ777Е хөрс	2	9,196,000.00	2	9,005,000.00	5,853,309.67	3,151,690.33
2.3	Дугуйт ачигч /том/	1	536,397.00	1	482,689.00	482,689.00	-
2.4	Дугуйт ачигч /жижиг/	3	872,500.00	3	725,400.00	725,400.00	-
2.5	Уурхайн зориулалттай суудлын Автомашин	5	937,900.00	6	913,000.00	913,000.00	-
2.6	Гидроэкскаватор /6.5 м3-с дээш/	1	4,400,000.00	1	3,600,000.00	2,340,002.00	1,259,998.00
2.7	Гидроэкскаватор /3.2-3.5 м3/	1	1,700,000.00	1	1,419,488.00	1,419,488.00	-
2.8	Гидроэкскаватор	1	1,705,000.00	1	1,485,635.00	792,339.04	693,295.96
2.9	Тэсэлгээний ачааны машин 5 тонн	1	165,000.00	1	135,300.00	135,300.00	-
2.1	Дотоод түлш тээврийн машин 5-8 тонн	1	275,000.00	1	225,500.00	225,500.00	-
3	Тоног төхөөрөмж	33	2,184,160.00		77,000.00	-	77,000.00
3.1	Зөөврийн цахилгаан үүсгүүр /сак/	1	77,000.00	1	77,000.00	-	77,000.00
4	Компьютер, дагалдах хэрэгсэл	16	44,066.00		38,836.00	38,836.00	-
4.1	Компьютер шинэчлэх	14	38,500.00	11	37,516.00	37,516.00	-
4.2	GPS хянах компьютер, МТИ-н өрөөний 55inch дэлгэц	1	4,950.00		1,320.00	1,320.00	-
5	Бусад үндсэн хөрөнгө	115	74,250.00		52,140.00	52,140.00	-
5.1	Уурхайн гар станц шинэчлэх	70	34,650.00	70	19,650.00	19,650.00	-
5.2	Богино долгионы суурин станц /уурхайн бүсэд/	45	39,600.00	45	32,490.00	32,490.00	-

6	Их засварын ажил	1	110,000.00	-	57,046.00	57,046.00	-						
6.1	Салбар төмөр замуудыг засварлах /Модон дэр, бетонон дэр, суман шилжүүлэг, суман дүнз/	1	110,000.00		57,046.00	57,046.00	-						
	НИЙТ ДҮН							186	37,658,273.00	147	25,646,763.00	18,935,417.29	6,711,345.71

2024 оны нийт хөрөнгө оруулалтын 25.6 тэрбум төгрөгийн 17.3 тэрбум буюу 68%-ийг санхүүжүүлсэн байна.

### ГУРАВ: САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

#### Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтүүд:

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны төлөвлөгөө /батлагдсан/	2024 оны гүйцэтгэл	2024 гүйц / 2024 бат.төл харьцуулалт		2024 гүйц / 2023 гүйц харьцуулалт	
						Хувь	Зөрүү	Хувь	Зөрүү
<b>Уулын ажлын үзүүлэлт</b>									
1	Нүүрс олборлолт	м.тн	2,479.07	2,400.00	2,633.31	109.72	233.31	106.22	154.24
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,477.47	2,380.00	2,623.55	110.23	243.55	105.90	146.08
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	8,109.24	7,840.00	9,484.17	120.97	1,644.17	116.96	1,374.93
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	1,988.57	2,050.00	1,667.05	81.32	(382.95)	83.83	(321.52)
5	Дахин шидэлт	м.м <sup>3</sup>	3,258.40	3,340.00	3,558.60	106.54	218.60	109.21	300.20
6	Нийт хөрс хуулалт	м.м <sup>3</sup>	10,097.81	9,890.00	11,151.22	112.75	1,261.22	110.43	1,053.41
7	Инженер ажил	м.м <sup>3</sup>	781.69	1,666.40	1,649.10	98.96	(17.30)	210.97	867.41
8	Нийт уулын цул	м.м <sup>3</sup>	16,186.71	16,879.87	18,535.20	109.81	1,655.33	114.51	2,348.49

2024 онд 2,400.0 мянган тонн нүүрс олборлон, 2,380.0 мянган тонн нүүрс борлуулах, 9,890.0 мянган м<sup>3</sup> хөрс хуулах төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр нүүрс олборлолт 2,633.3 мянган тонн, борлуулалтын хэмжээ 2,623.6 мянган тонн болж төлөвлөгөө 109.7-110.2 хувийн, хөрс хуулалтын хэмжээ 11,151.2 мянган м<sup>3</sup> болж төлөвлөгөө 112.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Хөрс хуулалтын ажлыг дотор нь салгаж үзвэл тээвэртэй хөрс хуулалт 9,484.2 мянган м<sup>3</sup> буюу 121.0 хувь, тээвэргүй хөрс хуулалт 1,667.1 мянган м<sup>3</sup> буюу 81.3 хувийн биелэлттэй ажилласан байна.

<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>10,741,117,127.43</b>	<b>21,872,068,391.13</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,618,578,058.60	19,068,528,348.74
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	122,539,068.83	2,803,540,042.39
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,741,117,127.43)	(21,872,068,391.13)
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>24,000,000,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	24,000,000,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>6,363,708,894.11</b>	<b>6,780,728,371.73</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,017,364,274.00	3,332,183,616.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,180,000,000.00	3,110,000,000.00
3.2.6	Буцалтгүй тусламж	166,344,620.11	338,544,755.73
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(6,363,708,894.11)</b>	<b>17,219,271,628.27</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,605,910,345.85</b>	<b>408,603,959.34</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,117,546,840.86	2,723,457,186.71
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,723,457,186.71	3,132,061,146.05

СНАГ-2025/060/НА-СТА-ТӨҮГ



## ДӨРӨВ:ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТАЛААР

Нэгдлийн стратегид охин компаниудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны OHSAS18001 стандартыг хэрэгжүүлнэ хэмээн зорьсны дагуу 2018 оноос “Шивээ Овоо” ХК-нд нэвтрүүлж эхлэн ХАБЭА-н удирдлагын тогтолцооны бодлого, зорилт, хөтөлбөр, төлөвлөгөө, удирдлага, ажилтнуудын үүрэг хариуцлагыг шинэчлэн баталгаажуулж ажлын байрны эрсдэлийг удирдан, тасралтгүй хяналтыг тогтоож, ажилтнуудад аюулгүй ажиллах соёл, хандлагыг төлөвшүүлэх сургалтуудыг хийж байна. Шивээ-Овоо ХК Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсээс уулын ажлын технологи ажиллагааны мөрдөлт, техник, авто, төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдал, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл эрүүл ахуй, ажилтнуудын эрүүл мэндийг хянан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг хангуулах, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилладаг.

Шивээ Овоо ХК нь ХАБЭА-н чиглэлээр хийж гүйцэтгэх үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөг жил бүр төлөвлөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажиллагсдын хөдөлмөрийн чадварыг хэвээр хадгалах, аюулгүй ажиллах зан үйлийг төлөвшүүлэх, ажлын байрны эрүүл ахуйг сайжруулах зорилгоор тэдгээрт зарцуулагдах хөрөнгийг жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Шивээ-Овоо ХК нь ХАБЭА-н бодлогыг боловсруулан Гүйцэтгэх удирдлагаар батлуулан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог байнга сайжруулах замаар эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох зорилт тавин ажилласан.

ХАБЭА-н сарын аяныг жил бүрийн 4, 10 дугаар саруудад тогтмол зохион байгуулан ажлын байрны эрүүл ахуй, нөхцөлийг сайжруулахад ажилтан, хамт олны оролцоог идэвхжүүлэн Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч хэсэг, нэгж уралдаан, Ажлын байрны орчны аюулыг илрүүлэх, мэдээлэх, арилгах уралдаан, АСТ-ыг зохион байгуулан шилдэг, сайн хэсэг, нэгж, ажилтнуудыг шагнаж урамшуулснаар ажилтнуудын мэдлэг, хандлага сайжирч байна

2024 онд ХАБЭА-н үйл ажиллагааны чиглэлээр 43, дотоод хяналтын чиглэлээр 19, эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр 13, ХАБЭА-н сургалтын чиглэлээр 31, ХАБЭА-н удирдлагын тогтолцооны чиглэлээр 2 нийт 108 ажил төлөвлөн хэрэгжүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар нийт гүйцэтгэл 98.1%-ийн гүйцэтгэлтэй байна.

### 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл

Хүснэгт № 52

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	АЖИЛ	ХИЙГДЭЭГҮЙ	ДУТУУ	ТАЙЛБАР
1	ХАБЭА-н үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөсөн ажил	43	0	0	100% хийгдсэн
2	ХАБЭА-н хяналтын чиглэлээр	19	0	0	100% хийгдсэн



3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эрүүл ахуйн чиглэлээр	13	1	0	Нийт ажилтнуудыг эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирлаар дүгнэх хойшлогдсон.
4	ХАБЭА-н сургалтын чиглэлээр	31	1	0	Нийт 31 төлөвлөгдсөнөөс 1 ажил хийгдээгүй бөгөөд ХАБЭА-н сургагч багшийн эрх авах сургалтад хамрагдах ажил хийгдээгүй ба байгууллагын нийт ажилтны сургалт зохион байгуулахад сургалт орж байгаа ажилтан нь заавал эрх авах сургалтад хамрагдсан байх ХНХЯ-наас шаардаж байгаа тул энэ сургалтад заавал хамрагдах шаардлагатай байна.
5	ХАБЭА-н удирдлагын тогтолцооны чиглэлээр	2	0	0	Стандартын сайжруулалт хийх, ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартын журам шинэчлэх ажил тогтмол хийгддэг.
	<b>Нийт</b>	<b>108</b>	<b>2</b>	<b>0</b>	
	<b>Гүйцэтгэл хувиар</b>	<b>98,1%</b>	<b>1,9%</b>	<b>0</b>	

### Эрүүл ахуйн чиглэлээр

Ажлын байруудаар 58 удаагийн ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг хийж илэрсэн зөрчлийг арилгуулах үүрэг даалгавар өгч биелэлтийг шалгаж бүртгэл хөтөлсөн.

Ажилчдын цайны газруудад хоол үйлдвэрлэлийн үеийн эрүүл ахуй, ариун цэвэрт нийт, 19 удаагийн хяналт, үзлэгийг хийж, заавар, зөвлөгөө өгөх, албан шаардлагын дэвтэрт хугацаатай үүрэг өгөх, эргэн шалгах хэлбэрээр гарсан зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажилласан.

### Хүснэгт №53


№	Төлөвлөгөө	Гүйцэтгэл %
1	Нийт ажилтнуудыг урьдчилан сэргийлэх хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Компанийн нийт ажилтнуудыг Улаанбаатар хотын “Гранд мед” эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг 12-р сараас 2024 оны 1-р сарын хооронд зохион байгуулж дууссан.
2	Хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох ажил мэргэжлийн жагсаалтын дагуу ажилтнуудад өдөр бүр ажлын байранд бүтээгдэхүүнийг олгох	Хэвийн бус нөхцөлөөр ажилдаг ажилтнуудад сар бүр ажиллах өдрийн тоогоор хор саармагжуулах бүтээгдэхүүн олгон бүртгэл хөтлөн тайлан гаргасан.
3	Ажлын байрууд болон машин техникуудад аптекийн ороох боох	АБХ-н ТАМ, ХММ, УНХ-н цахилгаан экскаваторуудад, Диспетчерийн ажлын байр, ТДХ-т аптекийн ороох боох материалууд байршуулсан.

	материалын бүрдүүлэлт хийх	
4	Ундны усыг мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторид шинжлүүлж дүгнэлт гаргуулах	ГС-н стандарт хэмжил зүйн газарт 2024.05 сард уулын цайны газар, технологи дамжлага, төв нөөц гэсэн 3 газраас шинжилгээ хийлгэсэн.
5	Хоол үйлдвэрлэлийн газрууд, дэлгүүрт хяналтын хуудсаар үйл ажиллагааг хянах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, зөвлөмж, албан шаардлага өгөх	Ажилчдын цайны газруудад хоол үйлдвэрлэлийн үеийн эрүүл ахуй, ариун цэвэрт тогтмол хяналт, үзлэгийг хийж, заавар, зөвлөгөө, хоол үйлдвэрлэлттэй холбоотой зөрчил арилгах албан шаардлага 4 өгч эргэн шалгах хэлбэрээр гарсан зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч ажилласан.
6	Нийт ажлын байруудад мэргэжлийн байгууллагаар шавьжгүйтэл, мэрэгчгүйтэл, халдваргүйтгэлийг жилд 2-с доошгүй хийлгэж хянах	Ажлын байруудад өдөр тутамдаа болон халдвар гарсан тохиолдол бүрд халдваргүйжүүлэлт тогтмол хийснээр ажлын байрнаас гарах халдварын тоо буурсан. <b>Халдваргүйжүүлэлт хийсэн тоо баримт:</b> 12-р сард нийт ажлын байруудад 17394 м2 талбайд шавж, мэрэгч устгал хийсэн.
7	Үйлчилгээний ажилтнуудад ариутгалын бодис найруулах хэрэглэх талаар зөвлөмж өгч, хяналтын хуудсаар хянах	ХДЦҮХ-ийн цэвэрлэгч нарт сар бүр цэвэрлэгээний материал, бодис хэрэглэх талаар зөвлөмж сургалт өгч, хяналт тавьсан
8	Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн батлуулах	Тус 2 төлөвлөгөөг шинэчилсэн бөгөөд 2025 оны төлөвлөгөөг 12-р сардаа багтаан “Налайх дүүргийн Уул уурхайн аврах албаны” даргаар батлуулсан.
9	Ажлын байруудын хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтүүд хийж ажлын байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах	Ажлын байрны гэрэлтүүлэг, агааржуулалт, тоосжилт, температур зэрэгт хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийн зөрчил, дутагдал илэрвэл арилгах арга хэмжээг авч ажилладаг
10	ХАБЭА-н хяналтын III шатны үзлэгийг зохион байгуулах	Улирал бүрийн сүүлийн сарын 3 дах долоо хоногт уурхайн аль нэг ерөнхий мэргэжилтний нэрэмжит болгон ХАБЭА-н хяналтын 3-р шатны үзлэгийг зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажиллаж байна.

### **ХАБЭА-н хяналтын чиглэлээр**


ХАБЭА-н хяналтын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, шалгалтыг ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, галын аюулгүй байдал, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн технологийн болон техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал зэрэг чиглэл тус бүрээр бүх ажлын байруудад зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж байна.

ХАБЭА-н хяналтаар илэрсэн зөрчил сүүлийн 5 жилээр



### ХАБЭА-н сургалт

Нийт ажилтнуудын аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн болон галын аюулгүйн дүрэм, шаардлагыг чанд мөрдүүлэх, аюулгүй ажиллах арга барилыг эзэмшүүлэх, улмаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох болон бататгахад чиглэгдсэн сургалтыг ХАБЭА-н хууль тогтоомж, ХАБЭА-н сургалт явуулах үлгэрчилсэн дүрэм MNS4969:2000 стандарт, НХХ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/173 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу зохион байгуулсан.



### ХАБЭА-н зарцуулсан биелэлт:

№	Зардлын нэр	Төлөвлөгөө /төг/	Гүйцэтгэл /төг/	Тайлбар
1	2024 оны хөдөлмөр хамгааллын хувцасны зардал	625,675,000.00	604,178,140.05	Нормын хувцас бүгд багтана
2	2024 оны хамгаалах хэрэгслийн нийт зардал			ХАБЭА-н хамгаалах хэрэгслүүд бүгд багтана
3	Витамин, аптек нийт зардал	15,600,000.00	15,854,359.09	Хэсгүүдийн нийт аптек, ажилтнуудад

				тараах жилийн хэрэглээний витамин
4	Хор саармагжуулах бүтээгдэхүүний нийт зардал	240,000,000.00	68,948,119.05	Хуульд заасны дагуу холбогдох ажилтнуудад олгоно
<b>Хөдөлмөр хамгааллын нийт зардал</b>		<b>881,275,000.00</b>	<b>688,980,618.19</b>	
5	2024 оны үйл ажиллагааны нийт зардал	194,950,000.00	121,390,205.91	Олон нийт, хэлтсээс зохион байгуулах арга хэмжээ
6	Материалын зардлын төлөвлөгөө	37,960,000.00	1,965,120.00	Аюулгүй ажиллагааны самбар
7	2024 оны эмнэлгийн багаж хэрэгслийн нийт зардал	17,576,000.00	1,714,555.53	Ажилтнуудын эрүүл мэнд, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх
8	ХАБЭА-тай холбоотой бусад зардал	44,090,000.00	34,952,976.54	Гамшгаас хамгаалах зардалд
<b>НИЙТ</b>		<b>1,175,851,000.00</b>	<b>849,003,476.17</b>	

ХАБЭА-н 2024 онд 172 цаг буюу 7 хоног сул зогссон бөгөөд шалтгаан нь цаг агаар, байгалийн хүчин зүйл, үер уснаас шалтгаалж зам талбайд ажил гүйцэтгэхэд эрсдэл үүсэж зогссон, карьерт ажиллах нөхцөл хүндэрснээс сул зогсолт хийсэн. Үйлдвэрлэлийн осол 2 удаа, осолд дөхсөн тохиолдол буюу техникийн аваар нийт 6 удаа гарсан байна.

Компанийн захиргаанаас нийт ажилтнуудад аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдлыг хангах дүрэм, зааврын шаардлагыг чанд мөрдүүлэх, аюулгүй ажиллах арга барилыг эзэмшүүлэх мэдлэг олгох болон бататгахад чиглэгдсэн сургалтыг холбогдох хууль тогтоомж журмын хүрээнд үе шаттайгаар холбогдох байгууллагуудтай хамтарч мөн дотооддоо зохион байгуулж байна. 2024 онд ХАБЭА-н хяналт шалгалт, үзлэгийг сайжруулж сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэн, үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн тохиолдлыг гаргахгүй байх хяналтыг бүх шатанд жигд тавьж ажилласан. Ээлжид ХАБЭА-н инженер тогтмол явж уурхай дээр 24 цагаар аюулгүй ажиллагааны хяналтыг тавьж ажилласан. 2024 онд ХАБЭА-н хэлтэс нь ажлын байран дахь зөрчил дутагдлыг олж илрүүлэх, арилгах, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

## **ТАВ:БАЙГАЛЬ ОРЧИНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ**

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай явуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлж, хохирлыг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг Монгол улсын “Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ууд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг компанийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт ажилтан, аж ахуйн нэгжүүдэд сахин мөрдүүлж, хэрэгжүүлэх, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хугацаанд нь гүйцэтгэхэд оршино.

➤ **Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулахад хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Д/д	Үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>АГААР</b>		
1	Уурхайн бүс доторх тоосжилт ихтэй орчинд Шивээговь сумын БОМ-ний хяналттай мониторингийн цэг тогтоон агаарын тоосны сорьц авч тодорхойлуулах.	Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториор агаарын бохирдлын шинжилгээг 6,10 сард нийт 6 цэгээс дээж авч дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран ажилчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.
2	Зам, талбайг усалж, чийглэх.	40-50тн-ы даацтай TEREX /2ш/ машинаар хоногт 12 рейс, 10 тн-ы даацтай DONGFENG машинаар хоногт 8 рейс усалгааг хийж уурхайн бүс доторх замын тоосжилтыг бууруулан ажиллаж байна.
3	Сайжруулсан зам хийж тоосжилтыг бууруулах.	УБ-ЗАМЫН ҮҮД чиглэлийн хатуу хучилттай авто замаас уурхайн шалган нэвтрүүлэх пост-3 хүртэлх 4.9 км уурхайн эзэмшлийн замыг сайжруулж, тус замаар зорчиж байгаа машин механизмын аюулгүй байдлыг ханган тоосжилтыг бууруулах арга хэмжээ авсан.
		Уурхайн бүс дотор шалган нэвтрүүлэх пост-1-ээс ТДХ конвейер хүртэлх замыг 2 урсгалтай болгох ажлыг зохион байгуулж бүрэн тэмдэглэгээ хийсэн.
4	Түлшээр ажилладаг тоног төхөөрөмжүүдээс ялгарах утааны хэмжээг хянаж, яндангийн оч баригч зэргийг тогтмол шалгаж, эвдэрсэн эд ангийг шинэчилж байх.	Уурхайн бүс доторх бүх талбай хамрагдах ба АБХ, УНХ, ТҮХ-ийн ерөнхий механикууд график гарган эвдрэл засварыг хариуцаж технологийн авто машинаас үүсэх хорт хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг авч ажиллаж байна.
5	Тэмдэглэгээ хийх, сайжруулах.	Уурхайн 1,2,3-р аманд өөрсдийн нөөц бололцоог ашиглан ТАМ-ны дугуйг будаж тэмдэглэж байршуулсан. Мөн карьерын зам талбайд шинээр 25 ширхэг тэмдгийг байрлуулсан.
6	Шалган нэвтрүүлэх пост-1-ийн гаднын тээвэр орж гарах гадна урсгалыг тусгаарлах хамгаалах даланг хийх.	Уурхайн шалган нэвтрүүлэх пост-1ийн нэмэлт Гаднын тээвэр нүүрс авахаар уурхайн бүсэд нэвтрэх хаалганы гаднаас орж гарах хөдөлгөөнийг тусгаарлах даланг хийж тэмдэг, тэмдэглэгээтэй болгож аюулгүй байдлыг бүрэн хангасан.
<b>ХӨРС</b>		
1	Эвдрэлд орсон газрын хөрсийг нөхөн сэргээх.	Хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор график гарган зөрчлийг арилган ажиллаж байна.
2	Шимт хөрсийг ангилан хуулах.	Биологийн нөхөн сэргээлт хийх талбайд буулган шимт хөрсжүүлсэн.
3	Хөрс шорооны овоолгыг төлөвлөсөн талбайд эмх цэгцтэй буулгаж нөөцөлж хадгалах.	Хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах зорилгоор уурхайн ашиглалтын талбайн үржил шимт хөрсийг гадаад овоолгын баруун хойд хэсэгт стандартын дагуу байршуулан нөөцөлж хадгалах ажлыг хийж гүйцэтгэв.

4	Шатах, тослох материалын хадгалалтад хяналт тавих, орчныг тусгай хучилттай болгох.	ШТС-ийн шатах тослох материалын хадгалалтын талбайд хөрс бохирдохоос сэргийлж 8х9 хэмжээтэй талбай мөн нөөцийн агуулахын гадна талбайг хатуу хучилттай болгон сайжруулж тохижуулав.
5	Хөрсний дээж авч бүтэц, шинж чанарыг орчны хяналт шинжилгээг Шивээговь сумын БОМ-ий хяналтын дагуу тодорхойлуулах.	ОХШХ-т тусгагдсаны дагуу Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лаборатори болон УБ хот дахь хөрсний бохирдлын болон хүнд металлын шинжилгээг 6,10 сард нийт 18 цэгээс дээж авч дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран ажилчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.
6	Нөхөн дүүргэх, овоолго хийх.	Хоосон орон зайг дүүргэж тээвэргүй хөрс хуулалтаар 1667.0 мян.м3 шороо шидэж нөхөн дүүргэлт хийгдсэн.
7	Техникийн нөхөн сэргээлт	Ашиглалт явагдсан 4.0 га газарт техникийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэсэн.
<b>УС</b>		
1	АБХ, ЗХ-ийн талбайнуудын орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байж, гадаргын уст цэгийн орчныг цэвэрлэх.	Жилд 2 удаа “Хаялга нуур”-ын ойр орчмын хогийг цэвэрлэж, ус бохирдохоос хамгаалав.
2	Усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу Шивээговь сумын БОМ-ий хяналттай хийлгэх.	ОХШХ-т тусгагдсаны дагуу жилд 2 удаа Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лаборатори болон УБ хот дахь усны хүнд металлын шинжилгээг 6,10 сард нийт 16 цэгээс дээж авч дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран ажилчдын аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.
3	Худагт тоолуур суурилуулах тусгай зөвшөөрөл авах, баталгаажуулах.	Усны үр ашигтай зарцуулалт нэмэгдэх, усны нөөцийг хамгаалах зорилгоор 8.10-р саруудад нийт 35 ш тоолуур баталгаажуулалт хийгдсэн.
4	Уурхайн ойролцоо хяналтын цооногт газрын доорх усны төвшингийн өөрчлөлтөд хяналт тавих.	Сар бүрийн 30,31-ний өдөр хяналтын цооногт төвшинг хэмжиж Усны сав газар, БОГазар, Шивээговь сумын байгаль хамгаалагч, уурхайн холбогдох хүмүүсээс бүрдсэн хяналтын хэмжилт, тоолуурын заалтаар акт үйлдэж баталгаажуулж байна.
5	Гүний худгийн шүүрэлтэд хяналт тавих.	7 хоногт тогтмол хэмжилт хийж мэдээлэл гаргаж хяналт тавьж байна.
6	Уурхайн ашиглалтын талбайг үерийн уснаас хамгаалан далан шуудуу татах.	Дулааны улиралд эрсдэл өндөртэй байршлуудад төлөвлөгөө гарган үерийн далан хаалт, шуудуу зэргийг сэргээн засварлаж гүйцэтгэсэн.
<b>УРГАМАЛ, АМЬТАН</b>		
1	Уурхайн олборлолтын талбайн талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тариалж ургамалжуулах, орчныг тохижуулах, мод бут сөөг тарих.	Ургамлан бүрхэвчийн доройтлоос сэргийлэхийн тулд нутгийн ургамлыг үрээр тарих ажлыг дотоод нөөцөө ашиглан хийж хэрэгжүүлсэн.
2	Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг технологийн дагуу гүйцэтгэх.	Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4.0 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн.
<b>ХОГ ХАЯГДАЛ</b>		
1	“Хаялга нуур”-ын хог цэвэрлэх	

		Төлөвлөгөөний дагуу “Хаялга нуур” орчмын хог цэвэрлэгээг 2024 онд 3 удаа зохион байгуулсан. 1. “Шивээ-Овоо” ХК-ийн “Хаялга нуур”, уурхайн гаднах зогоонийг тойрсон 3-4 км-ийн радиус талбай, босоо тэнхлэгийн засмал зам дагуу явж сэг зэмийг цуглуулан ачиж тээвэрлэн 21-р зөрлөгийн төвлөрсөн хогийн цэгт хаяхдаа ариутгал халдваргүйжүүлэлт хийн устгах ажлыг зохион байгуулсан. 2. “Хаялга нуур”-ын ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгүүдийг нуурын эргээс 200метрийн зайд шилжүүлэн байршуулав. 3. “Хаялга нуур”-ын ойр орчим болон, хогийн цэгүүдийн хог хаягдлыг цэвэрлэв.
2	Ахуйн хатуу хог хаягдлыг Ландфиллийн хүнхээлд тээвэрлэн хүргэж, устгах.	Уурхайн ахуйн хог хаягдлыг график гарган устгасан.
<b>АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ</b>		
1	Хог хаягдлын цэг, бохирын цооногт тогтмол ариутгал хийх.	Хог хаягдлын цэг, бохирын цооногт тогтмол ариутгал хийх ажлыг ХАБЭА Хэлтэстэй хамтран график гарган гүйцэтгэсэн. Мөн уурхайд байрлах нүхэн жорлонгуудад ариутгал хийж устгасан болно.
2	Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах, тохирох аргын дагуу зайлуулах, устгах.	Аюултай хог хаягдал болох масло, тосны шүүр, агаар шүүгч болон галын хор зэргийг консервацид ангилан хадгалж байгаа. Ажилласан маслыг тусгай зөвшөөрөлтэй “Об ойл индустриал” ХХК-тай гэрээ байгуулан устгуулсан.
3	Аваарын эмнэлгээс гарах аюултай хог хаягдлыг устгах.	Шивээговь сумын Нэгдсэн эмнэлэгтэй хамтран гэрээ байгуулан /Аюултай хог хаягдлын журмын дагуу/ ажиллаж байна.

➤ **Уул уурхайн нөхөн сэргээлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ /дүйцүүлсэн тухай/**

Дүйцүүлэн хамгаалах газрыг сонгохдоо экологийн хувьд ижил байх, нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, хугацааг нөлөөлөлтэй харьцангуйгаар тогтоох зарчмыг баримталж БОНБҮ-ий тухай хуулийн 3.1.11, 9.6-д заасны дагуу авч хэрэгжүүлэв.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангийн дүйцүүлэн хамгаалах зорилт, чиглэлд тусгагдсан үйл ажиллагааны 2.2-д Биотехникийн арга хэмжээний 2.2.1., 2.2.3.-д тусгагдсан ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн Байгаль орчны газрын санал хүсэлтийн дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 2-р багт /L-49-49/ орших Чойрын богд уулын Байгалийн дархан цаазат газар нутагт байрлах хүн, машин тэрэг бага холхидог газарт зэрлэг ан амьтан Аргалын сүргийг ундаалах зориулалтаар ашиглах “Хөв цөөрөм” байгуулах, Ламын худгийн таг, үерт орж нурсан нүх зэргийг чулуугаар хашиж, засварлан нөхөн сэргээж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэв. Тус ажилд “хөв цөөрөм” байгуулж талбайд хийгдсэн цөөрмийн газар шорооны ажил, талбайг тэгшлэх, мембран дэвсэж бетон зуурмагийг 0.10 метр зузаантайгаар тарааж цутгаж дүүргэн цөөрөм үүсгэж фото зураг болон маркшейдерийн хэмжилт хийж дэвсгэр зурагт буулгав.

➤ **Усны хэмжээ, бохирдлын хяналт**

Ус шүүрүүлэх нь 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар В, С, 16, D шугамд жилийн дунджаар нийт 39 худаг ажиллаж, 3153.6 мян.м3 ус уурхайгаас зайлуулахаар төлөвлөснөөс нийт 16 худаг ажиллаж 837.3 мян.м3 ус уурхайгаас зайлуулж биелэлт 27.0 %-тай, усны түвшинг хяналтын цооногуудын дунджаар оны эхнээс буурсан үзүүлэлтийг ашиглалтын ам тус бүрээр харахад I ам 1132.79 – өөс 1134.05 түшинд 1.26 м-ээр өсөлттэй, II ам 1123.09 – өөс 1120.72 түшинд -2.36 м-ээр бууралттай, III ам 1114.00 –оос 1111.80 түшинд -2.20 м-ээр буурсан байна. Уурхайн ашиглалтын I, II, III амуудын усны түвшингийн дундаж 1123.39 – 1122.19 түвшинд -1.10 м-ээр буурчээ.

2024 оны ус шүүрүүлэхийн төлөвлөгөөнд D47, D48, D49 дугаартай 3 ширхэг цооног 563 уртааш метр, өрөмдөж монтажлан ашиглалтад оруулахаас ашиглалтын D47, D48, D49 дугаартай 3 ширхэг цооног 563 уртааш метр өрөмдөж, яндан труба суулгаж, 72 цагийн шавхалт, угаалтын ажлыг гүйцэтгэн ундаргыг тогтоож монтажлан ашиглалтад оруулаад ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу нийт 35 худагт засвар үйлчилгээ, дулаалга, шугамуудын даланг сэргээн засварлаж 2024-2025 оны өвөлжилтийн бэлэн байдал 100%-ийн биелэлттэй ажиллаж байна. Хавсралтаар : Ус шүүрүүлэхийн 2024 онд шавхан зайлуулсан усны мэдээ тоолуурын заалтаар тодорхойлсон актыг харуулав.

➤ **Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн**

Д/д	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын тарилтад 5000 ширхэг мод тарих.	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын тарилтад 5000 ш хайлаас модыг технологит хугацаанд тарьж арчилгаа тордлогоо усалгааг графикайн дагуу хийсэн.
2	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн бүс дэх төлөвлөгдсөн 7,5 га талбайд 15000 ширхэг мод тарих.	2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн бүс дэх төлөвлөгдсөн 7,5 га талбайд шан татах аргаар хайлаас-13930 ширхэг, жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд хайлаас - 850 ширхэг, жимсний болон гоёл чимэглэлийн 220 ширхэг нийт 15000 мод, сөөгөөр тарилт хийв. Мөн хаврын улирлын тариалалтад ашиглах хайлаас - 15000 ширхэг, улиас - 3000 ширхэг, шар хуайс - 2000 ширхэг нийт 20000 модыг Монгол улсын стандартын дагуу хадгалав.



№	Хуваарьт он	Төлөвлөгөө Тарих модны тоо /ширхэг/	Гүйцэтгэл Таригдсан модны тоо /ширхэг/	Төсөв /мян.төг/
1	2021	5000	1250	1000.0
2	2022	10000	3600	19800.0
3	2023	15000	5000	19000.0
4	2024	30000	20000	221000.0
5	2025	40000	30000	818000.0
	<b>Нийт</b>	<b>100000</b>	<b>59850</b>	<b>1078800.0</b>

## ЗУРГАА:УДИРДЛАГЫН БУСАД ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР

### Байгууллагын соёл:

Тус байгууллага нь 2024 онд байгууллагын соёлын талаар судалгаануудыг хийн дүгнэж ажиллалаа.

Байгууллагын соёлын судалгааны асуулт

#### Миний байгууллага

1. Би компанийнхаа эрхэм зорилго, алсын харааг ойлгодог
2. Би компанийнхаа эрхэм зорилгыг өдөр тутмынхаа ажилд тусган ажилладаг
3. Компанийн зорилгод хүрэхэд миний хийж буй ажил чухал нөлөөтэй
4. Компанийн тайлагнах процесс, ажил үүрэг, хариуцлагын систем тодорхой, ойлгомжтой байдаг

#### Миний ажил

5. Би компанийн амжилтад хувь нэмрээ оруулж чаддаг.
6. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөөц надад байдаг
7. Би хийж буй ажлаасаа үргэлж сурч хөгждөг
8. Би ажил дээрээ өөрийн давуу тал, ур чадвараа бүрэн ашигладаг
9. Би компанидаа өөрийн цаашдын карьераа эергээр харж чаддаг

#### Миний баг, ажлын орчин

10. Миний хамтран ажиллагсад нэг нэгэндээ хүндэтгэлтэй ханддаг
11. Багийн гишүүн бүрийн санаа бодол бидний ажилд шингэдэг
12. Багийн гишүүд багийн зорилгоо хувь хүний зорилгоос илүүд үздэг
13. Манай хамт олон эвсэг, нэг баг болж ажилладаг

#### Манлайлал

14. Удирдлага надад хүндэтгэлтэй ханддаг
15. Удирдлага намайг сурч хөгжихөд тусалдаг
16. Удирдлага миний ажил дээр гаргаж байгаа хүчин чармайлтыг ойлгодог
17. Удирдлага бүх хүнтэй адилхан хүндэтгэлтэй, шударга харьцдаг
18. Удирдлага биднийг манлайлж, үлгэрлэж чаддаг

Асуултууд

19. Компанийн давуу талыг тодорхойлж бичнэ үү
20. Компанид сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлж бичнэ үү

	Сайжруулах шаардлагатай хэсгүүд	Одоо байгаа түвшин	Хүрэх түвшин	№	Гүйцэтгэх ажил
1	Компанийн тайлагнах процесс, ажил үүрэг, хариуцлагын систем тодорхой, ойлгомжгүй байдаг	0.34	0.7	1	Бүх ажилтнуудад байгууллагыг таниулах сургалтыг бүх алба, хэсгээр дахин зохион байгуулах
				2	Ажлын байрны шинжилгээ хийх /Шаардлагатай/
				3	Ажил үүргийн хуваарийг шаардлагатай ажлын байрт шинэчлэн гаргаж танилцуулах
				4	Компанийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах
				5	Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах
				6	Хэсэг, алба хоорондын ажлын уялдааг сайжруулах төлөвлөгөө гаргаж зохион байгуулах
				7	Ажилтнуудад ил тод байж болох ХН-ийн журам бүхий л мэдээллийг ойлгомжтойгоор ажилтнуудад хүргэх ажил өрнүүлэх /ХН-ийн ойлгомжтой цэс/
2	Би компанидаа өөрийн цаашдын карьераа эерэгээр харж чаддаг	0.54	0.7	1	Албан тушаал бүрд тохирсон карьер хөгжлийн төлөвлөгөө боловсруулах
				2	Шинээр орж байгаа ажилтан бүрд дасан зохицох хөтөлбөр танилцуулах.
				3	Шинэ ажилтны чиглүүлэх хөтөлбөрийг сайжруулах
3	Багийн гишүүд багийн зорилгоо хувь хүний зорилгоос илүүд үздэг	0.52	0.7	1	Ажилтан бүрийн ажил үүрэгтэй нь байгууллагын Чадварлаг ажил гориллогчийг хэрхэн холбох талаар нэгдсэн нэг ойлголт өгөх.
				2	Удирдах ажилтан бүр сургалт, уулзалт зохион байгуулж ажилтнуудтайгаа ажиллах хуваарь гарган ажиллах

				3	Сайн дурын клубүүдийг байгуулан зохион байгуулж ажиллах. Тодорхой төсөв баталж өгөх
				4	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах комисс гаргах, олон нийтийн арга хэмжээ тогтмол зохион байгуулах
4	Удирдлага надад хүндэтгэлтэй ханддаг	0.54	0.7	1	Удирдах ажилтнуудыг чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх
				2	Удирдах ажилтан бүр сургагч байх ажлыг эхлүүлж он дуусахаас өмнө удирдах ажилтан бүр өөрийн гэсэн 1 сэдэвтэй болсон байх ажлыг зохион байгуулах
5	Удирдлага намайг сурч хөгжихөд тусалдаг	0.38	0.6	1	Ажилтан төвтэй байх хөтөлбөрийг удирдлага болгон дор бүрнээ боловсруулж хэрэгжүүлэн ажиллах
				2	Уулзалтын тэмдэглэлийн хуудсыг ХН бэлтгэж өгөх
				3	Ажилтан бүрийн ажил , хөгжлийн төлөвлөгөөг өөрөөр нь бөглүүлж аваад үүний хүрээнд Ажилтантайгаа уулзалт хийж байх.
				4	Ажил, хөгжлийн төлөвлөгөөний заавар, загварыг Хүний нөөцөөс бэлтгэж өгөх
6	Удирдлага миний ажил дээр гаргаж байгаа хүчин чармайлтыг ойлгодог	0.43	0.6	1	Ажилтнуудыг сайшааж, шагнах арга ухааны талаар сургалт, зөвлөгөө өгөх
				2	Сайшаал шагналын журмыг ажилтан бүрд ойлгомжтой байдлаар танилцуулах
				3	Компанийн ажилтнуудын фасебүүк, дотоод мэдээллийн хуудсаар алдаршуулах ажлыг зохион байгуулах
7	Удирдлага бүх хүнтэй адилхан хүндэтгэлтэй, шударга харьцдаг	0.39	0.7	1	Харилцааны соёл, ёс зүйн талаар удирдах ажилтнуудад ахисан түвшний сургалт зохион байгуулах
				2	Үүний хүрээнд ажил дээр хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тест, судалгаа авах.
				3	Хамгийн харилцаа сайтай, үнэлгээ өндөртэй байсан удирдлага, ажилтнуудыг алдаршуулах ажил зохион байгуулах

## ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО ШИЙДВЭР, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг, даалгавар	Биелэлт тооцох хугацаа	Биелэлтийн явц, үр дүнгийн талаар	Биелэлт хувь
<b>ТӨРИЙН БОДЛОГО, ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ДАГАЖ МӨРДСӨН ТУХАЙ</b>				
1	Хууль тогтоомж	2024.01.01-2024.12.31	“Шивээ Овоо” ХК үйл ажиллагаандаа Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан 88 хуулийг мөрдлөг болгон ажиллаж байна. Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль гэх мэт.	<b>100%</b>
<b>УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ</b>				
1	Засгийн газрын тогтоол	2024.01.01-2024.12.31	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43, 345, 2022 оны 203, 204 2023 оны 49, 84 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	<b>100%</b>
<b>НЭГДЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНД КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ НИЙЦҮҮЛЭХ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭСЭХ.</b>				
1	Нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлэх удирдан зохион байгуулсан эсэх.	2024.01.01-2024.12.31	Эрдэнэс Монгол нэгдлийн дунд хугацааны 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилго, 5 стратегийн чиглэлийн хүрээнд компанийн мөн хугацаанд мөрдөх стратеги төлөвлөгөөг боловсруулан толгой компанид хүргүүлэн ажилласан.  Эрдэнэс Монгол нэгдлийн стратеги төлөвлөгөөнд компанийн үйл ажиллагааг нийцүүлэн ажиллаж байна.	<b>100%</b>
<b>ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИАС ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ</b>				
1	Эрдэнэс Монгол ХХК-иас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт	2024.01.01-2024.12.31	“Эрдэнэс Монгол” ХХК-иас нийт 55 үүрэг, даалгавар ирүүлснийг биелүүлэн холбогдох тайлан мэдээллийг хүргүүлэн ажилласан.	<b>100%</b>
<b>ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>				
1		2024.01.01-2024.12.31	Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2024 онд өгсөн 17 үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан.	<b>94,5%</b>

2024 онд компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан эрх зүйн маргаан, зөрчил үүсээгүй. Харин компанийн эзэмшлийн газрын төлбөртэй холбоотой маргаан үүссэнийг судалгаагаар гарган харуулав.

д/д	Иргэн, хуулийн этгээдийн нэр	Шүүх	Нэхэмжлэл гаргасан огноо	Нэхэмжлэлийн шаардлага, үнийн дүн	Шийдвэрлэлт
1.	Говьсүмбэр аймгийн Прокурорын газар	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2024.06.24	Газрын төлбөр 218.206.080 төгрөг гаргуулах тухай 2022-2023 оны газрын төлбөр	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 134/ШШ2024/00217 дугаар шүүгчийн захирамжаар 218.206.080 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагаас 109.103.040 төгрөгийн шаардлагаас нэхэмжлэгч татгалзаж 109.103.040 төгрөгийн төлбөрийг Шивээ Овоо ХК Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын төсвийн дансанд төлж барагдуулахаар эвлэрлийн гэрээ байгуулсныг баталсан. Төлбөр төлөгдөөгүй 109.103.040 төгрөгийн үлдэгдэл төлбөртэй.
2.	Говьсүмбэр аймгийн Прокурорын газар	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2024.06.24	Газрын төлбөр 9.100.725 төгрөг гаргуулах тухай 2022-2023 оны газрын төлбөр	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 134/ШШ2024/00209 дүгээр шийдвэрээр Шивээ Овоо ХК-иас 9.100.725 төгрөгийг гаргуулж Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн дансанд оруулахаар шийдвэрлэсэн. Төлбөр төлөгдөөгүй 9.100.725 төгрөгийн үлдэгдэл төлбөртэй.
3.	Говьсүмбэр аймгийн Прокурорын газар	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2024.06.24	Газрын төлбөр 3.467.161 төгрөг гаргуулах тухай 2022-2023 оны газрын төлбөр	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 134/ШШ2024/00211 дүгээр шийдвэрээр Шивээ Овоо ХК-иас 3.467.161 төгрөгийг гаргуулж Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн дансанд оруулахаар шийдвэрлэсэн. Төлбөр төлөгдөөгүй 3.467.161 төгрөгийн үлдэгдэл төлбөртэй.
4.	Говьсүмбэр аймгийн Прокурорын газар	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2024.06.24	Газрын төлбөр 16.972.447 төгрөг гаргуулах тухай 2022-2023 оны газрын төлбөр	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 134/ШШ2024/00212 дугаар шийдвэрээр Шивээ Овоо ХК-иас 16.972.447 төгрөгийг гаргуулж Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн дансанд оруулахаар шийдвэрлэсэн. Төлбөр төлөгдөөгүй 16.972.447 төгрөгийн үлдэгдэл төлбөртэй.
5.	Говьсүмбэр аймгийн Прокурорын газар	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2024.06.24	Газрын төлбөр 1.120.725 төгрөг гаргуулах тухай 2022-2023 оны газрын төлбөр	Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 134/ШШ2024/00210 дүгээр шийдвэрээр Шивээ Овоо ХК-иас 1.120.725 төгрөгийг гаргуулж Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн дансанд оруулахаар шийдвэрлэсэн. Төлбөр төлөгдөөгүй 1.120.725 төгрөгийн үлдэгдэл төлбөртэй.

“Шивээ Овоо” ХК-нд 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа иргэний хэрэг маргаан байхгүй.

## Нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутгийн хэмжээнд хийсэн ажлууд

Дэлхий нийтээр компанийн нийгмийг хариуцлага гэсэн ойлголт, үйл ажиллагааг улам эрчимжүүлж, өргөтгөж байгаа өнөө үед монголын компанид ч энэ асуудалд анхаарлаа хандуулан өөрсдийн бодлого, үйл ажиллагаанд тусгаж нийгэмд тусгай ажил хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

➤ 2024 оны 12 дугаар сарын байдлаар тус уурхайд нийт 93 ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласнаас 72 иргэн буюу 77% нь орон нутгийн иргэн байна.

➤ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 30 иргэнийг ажлын байраар ханган ажилласан.

➤ “Шивээ Овоо” ХК нь Нийгмийн хариуцлагын хүрээнд Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын сургуулийн өмнөх боловсролын 3-р цэцэрлэгийн багш, хүүхэд багачуудыг аюулгүй, тохилог орчинд сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс 182 хүүхдийн хувцасны шүүгээ, 8 ширхэг багшийн ширээ, 2 танхимын хивсэнцрийг хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

➤ “Шивээ Овоо” ХК-иас зохион байгуулсан Ерөнхий боловсролын сургуулийн сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн 2024 оны 3 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд 5-7 анги, 8-9 анги, 10-12 ангиудын дунд 3 үе шаттайгаар зохион байгуулагдаж 250 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

➤ Шивээговь сумын 3 дугаар сургуулийн биеийн тамирын спортын хэрэглэгдэхүүн болох онооны самбар, сагсан бөмбөг, гар бөмбөг, сандал, бөмбөгний сав /г.м/, сургуулийн гадна орчны болон доторх хяналтын камержуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн;

➤ Компанийн дотоод журам, хамтын гэрээнд заасны дагуу компанийн ажилтнууд болон тус компанийн харьяа өндөр настнуудад журмын дагуу буцалтгүй тусламж, тэтгэмж, нөхөн төлбөр, хоолны үнийн хөнгөлөлт, нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлж ажилласан.

➤ Шивээ Овоо ХК-ийн Нийгмийн хариуцлагын хүрээнд Шивээговь сумын төв талбайн гэрэлтүүлгийн ажлыг иж бүрнээр нь гүйцэтгэж Сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгсөн.

➤ Сумын засаг даргын хүсэлтийн дагуу шаардлагатай үед /хогийн цэг шилжүүлэх, ачих бусад үйлд ажиллагаанд/ техник тоног төхөөрөмжийг олгож хамтран ажилласан.

## Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар

“Эрдэнэс монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 24 дүгээр тогтоолоор нэгдлийн хэмжээнд мөрдөгдөх “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг”. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/43 дугаар тушаалын дагуу компанийн 2024 оны эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Компанийн Эрсдэлийн төлөвлөгөөг Эрдэнэс монгол ХХК-нд хүргүүлж биелэлтийн тайланг улирал бүр тайлагнан ажилласан. Мөн “Шивээ Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/58 дугаар тушаалаар “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулан мөрдөн ажиллаж байна.

Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулахад хэрэгжүүлэх ажлын чиглэл бүрээр эрсдэлийг урьдчилан тооцоолж Эрдэнэс монгол ХХК-д хүргүүлэн ажилласан.

Эрдэнэс Монгол ХХК-тай хамтарч компанийн инженер техникийн ажилтнууд болон Эрсдэлийн төлөвлөгөө тайлан боловсруулах, дүгнэх ажилтнуудад цахим болон танхимын хэлбэрээр “Нэгдлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх жишиг аргачлал”, Эрсдэлийн удирдлагын бодлогын барим бичиг” сургалтуудад хамрагдан, заавар зөвлөмж аван ажиллаж байна.

Захиргаа хөгжлийн бодлогын хэлтсийн 2024 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалт явуулах” журмын дагуу нийт 35 удаа хяналт шалгалт хийсэн байна. Журмын дагуу төлөвлөгөөт 28, төлөвлөгөөт бус 5, гэнэтийн шалгалт 2 тус тус гүйцэтгэж, санал дүгнэлтээ гүйцэтгэх удирдлагуудад илтгэх хуудсаар танилцуулсан байна.

Төлөвлөгөөт шалгалтаар компанийн гүйцэтгэх захирлын тушаалын хэрэгжилт, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн хууль – дотоод журмын хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль, төрийн хэмнэлтийн хууль, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын хэрэгжилт, сургалтын журам, хүний хөгжлийн төлөвлөгөө, өргөдөл гомдлын шийдвэрлэлт зэргийг шалгаж, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ тухай бүр нь авах, эргэж гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллав.

Төлөвлөгөөт бус шалгалтаар уулын хөрс хуулалт, бүтээлтэй ажлын цагийг нэмэгдүүлэх, өвөлжилтийн бэлтгэл хангасан байдал, уурхайд ашиглагдаж буй нийт халаагуурын ашиглалт ,ажлын байрны эмх цэгц, тохижилтын байдал зэрэгт гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж , санал дүгнэлтээ захирлын зөвлөлийн хуралд тухай бүрд нь танилцуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулав.

Гэнэтийн шалгалтыг уурхайн бүсэд ажиллаж байгаа өөрийн үндсэн хэсгүүд болон түрээсийн гэрээтэй хөрс хуулалтын компанийн ажлын цаг ашиглалтад дангаар болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран шалгалт хийж, бүтээлтэй цагийг нэмэгдүүлэх, ажлын байрны тодорхойлолт , хөдөлмөрийн болон түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг ажил олгогч болон хамтран ажиллагч байгууллагад анхааруулж, бодит байдлыг гүйцэтгэх удирдлагад илтгэх хуудсаар мэдээлэл өгч ажиллав.

ТАНИЛЦСАН:



Ц.ЭНХТҮВШИН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:



Б.ГЭРЭЛТУЯА  
ОНХ мэргэжилтэн

ХЯНАСАН:



Ч.ЭНХЖАРГАЛ  
ЗХБХ-ийн ДАРГА